

**ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР
ХЭРЭГЖИЖ БУЙ “МОНГОЛ НОГОО” ТӨСЛИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	“Монгол ногоо” хөтөлбөр-Төгсгөлийн үе шат Хэрэгжих хугацаа:2016-2020 7F-09387.01.01 Гэрээ №81014302	Хөтөлбөрийн зорилго: Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа	<p>Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо <u>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</u> Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага <u>Үндэсний түнш байгууллагууд:</u> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 1.1. Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Сонгино-Хайрхан, Налайх, Хан-Уул дүүргийн хүнс хөдөө аж ахуйн хэлтэс Орон нутгийн засаг даргын тамгын газар Ургамал газар тариалангийн хүрээлэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн Хандивлагч байгууллагууд/Олон Улсын ТББ-ууд Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төсөл, Сонгогдсон дүүргүүдийн гэр хорооллын цэцэрлэг, сургуулиуд (ШХА) ЕХ/ДХХААБ ажлын байрыг дэмжих төсөл SECiM 2 Хувийн хэвшлийн байгууллагууд (бөөний зах гэх мэт)</p>		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм. Үр нөлөө 1: Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хаут үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Үр нөлөө 2: Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсоноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна. Үр нөлөө 3: Хотын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдүүлсэн байна. Үр нөлөө 4: Хүнсний ногооны салбарын бодлого/хууль эрх зүйн орчин сайжирсан байна.</p>		
5	Төсөв	8.8 тэрбум төгрөг (5 сая швейцар франк) /Зорилт 1,2,3/		
	Үүнд :	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
	2016 он	2,400,000,000	1,718,295,273	71.0
	2017 он	2,975,181,937	2,396,168,919	80.5
	2018 он	3,100,083,697	2,479,844,281	80.0
	2019 он (Бүрэлдэхүүн хэсэг I-III, төгрөг)	2,287,011,121.0	2,045,420,046.4	(89%)
	(Бүрэлдэхүүн хэсэг IV, доллар)	175,690	149,542	(85%)
ХХААХҮЯ /шууд бус/	-	-	-	

6	Хөтөлбөрийн зорилт :	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичсэн.
	Бүрэлдэхүүн хэсэг-1	Үнэлгээний тайлангийн 8-12 дугаар хуудас
	Бүрэлдэхүүн хэсэг-2	Үнэлгээний тайлангийн 12-15 дугаар хуудаснаас харна уу.
	Бүрэлдэхүүн хэсэг-3	Үнэлгээний тайлангийн 15-18 дугаар хуудаснаас харна уу.
	Бүрэлдэхүүн хэсэг-4	Үнэлгээний тайлангийн 18-22 дугаар хуудаснаас харна уу.
7	ДҮГНЭЛТ (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Төслийн гүйцэтгэлд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээний хийхэд 82.4 хувьтай биелсэн байна. Монгол ногоо төслийн I дүгээр үе шат хэрэгжсэнээр дараах бодит үр дүнгүүд гарсан байна.</p> <p>1.Төслийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Төвийн бүсийн 4 аймгийн 12 сумын хүнсний ногооны тариалалт улсын хэмжээний тариалалтын 36.8-40.8 хувийг эзлэж жил бүр өсөлттэй гарлаа. Хураан авсан хүнсний ногооны хувьд улсын хэмжээнд хураасан ургацын 32.2-43.7 хувийг эзэлж жил бүр өсөж байна. Эндээс дүгнэж үзэхэд “Монгол ногоо” төслийн хүрээнд үйлдвэрлэлд нэвтрүүлж нутагшуулсан ургац өндөртэй шинэ сортын үрээр хангах, ногоочдын технологийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын үр дүнгээр ногоо тариалах сонирхол, нэгжээс авах ургац нэмэгдэж байна.</p> <p>2.Төсөл хэрэгжсэнээр хүнсний ногоо тарьдаг иргэдийн орлого эрс нэмэгдсэн гэсэн судалгааны дүн гарсан байна. Үндэсний статистикийн судалгаагаар хөдөөгийн өрхийн сарын орлого сүүлийн 3 жилийн туршид 11.49 % өссөн байхад төслийн хамрах нутгийн ногоочин өрхийн сарын орлого 2015 оны суурь үнэлгээтэй харьцуулахад 83.2% иар өссөн байдалтай байна. Судалгаанд оролцсон өрхийн 86%-ийн өрхийн орлого ногооны борлуулалтаас бүрдэж байна.</p> <p>3.Хүнсний ногооны үр үйлдвэрлэл, борлуулалтын зөв тогтолцоог бий болж эхэлсэн. Үүнд үр үйлдвэрлэгчдийг чанартай, стандартын шаардлага хангасан үр үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж, МХШТФХ-ны дэргэдэх үрийн нэгдсэн нөөцийн санг бүрдүүлж ажилласнаар үрийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ногоочдод найдвартай, чанартай үр нийлүүлэх систем бүрдсэн байна.</p> <p>4.Хүнсний ногооны үр хадгалах зориулалтын зоорийг төслийн зүгээс шинээр барьж байгуулсан нь үрийн чанар алдагдахгүй, аюулгүй орчинд /бороо, ус, гал түймэр/ байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд автагдахгүй байх боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>5.Гэр хороололд хүнсний ногоо тариалахад гол бэрхшээл болдог усны асуудлыг шийдвэрлэхэд нь төсөл болон нийслэлийн дүүргүүд хамтран дэмжлэг үзүүлж “Жишиг гудамж”, “Загвар өрх”-үүд бүхий загварыг санаачлан хэрэгжүүлсэн.</p> <p>6.Төслийн “Жишиг гудамж” аргачлал үр дүнтэй өгөөжтэй загвар болж байгаа нь аймгууд болон нийслэлийн дүүрэг хороод орон нутгийн хөрөнгө оруулалтаар загварыг хэрэгжүүлэхээр төслөөс мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах хүсэлтээ уламжилж, хамтарч ажиллаж байна. Уг аргачлал орлого багатай гэр хорооллын иргэдэд хашаандаа ногоо тариалах, хэрэглэж занших, эрүүл аюулгүй хүнсээр өрхийн хэрэгцээнд ашиглахаас гадна өрхийн орлогоо нэмэгдүүлэх санаачлага гаргахад сайнаар нөлөөлж байна.</p> <p>7.“Органик хүнсний тухай хууль”-нд заасан баталгаажуулалт хийх арга хэлбэрийн нэгийг хэрэгжүүлэх хамтын баталгаажуулалтын байгууллага (ХББ) 2019 оныг хүртэл нэг ч байгуулагдаагүй байсан бол төслөөс зохион байгуулсан сургалтын үр дүн, дэмжлэгтэйгээр “Органик хөгжил” ХББ болон</p>

		<p>“Борнуур Органик Хүнс” ХББ байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн.</p> <p>8.Төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан “Органик хөгжил” ХББ нь өөрийн гишүүн “Гэр гарден органик” ХХК-ийн тарьж ургуулсан нийт 13 төрлийн хүнсний ногоог органик аргаар үйлдвэрлэснийг баталгаажуулан ХХААХҮЯ-ны www.organic.gov.mn сайт дахь органик хүнсний улсын бүртгэлд бүртгүүлэн органик шошготойгоор зах зээлд нийлүүлж байна.</p> <p>9.Төслийн үр дүнд хүнсний ногооны үр үйлдвэрлэл нэмэгдэж, тариаланчид баталгаатай үрээр тариалалт хийх боломж бүрдэж, үрийн чанар дээшилсэн, мөн дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж төслийн үр шим хүртэгчдийн санхүүгийн чадавх дээшилсэн сайн үзүүлэлтүүд гарч байна.</p> <p>ЗӨВЛӨМЖ</p> <p>Төслийн үр дүнг дээшлүүлэх, II дахь шатыг амжилттай хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах чиглэлд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:</p> <p>1.Төслийн үр дүнг дээшлүүлэх үүднээс төслийн эхний үе шатанд хангалтгүй хэрэгжсэн, сайжруулах шаардлагатай үйл ажиллагаануудыг төслийн II дахь шатны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг,</p> <p>2.Хүнсний ногооны салбарт ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, ургамал хамгааллын хуулийг боловсруулах ажлыг тус тус эрчимжүүлэх ажлыг төслийн 4 дэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үргэлжлүүлэн зохион байгуулалж ажиллахыг,</p> <p>3.Хүнсний ногооны маркетингийн сувгуудыг боловсронгуй болгох, борлуулалтын хоршоо байгуулах, хоршооллоор дамжуулсан хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэх, бренд бүтээгдэхүүн бий болгох ажлыг төслийн дараагийн үе шатанд илүү сайжруулахыг,</p> <p>4.Хүнсний ногооны үрийн нөөц сангийн бизнес төлөвлөгөөг сайжруулан 3-5 жилээр гаргаж ажиллахыг,</p> <p>5.Сургалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдагсад сурсан туршлагаа хэрхэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдалд хяналт тавьж ажиллах, үр дүнг тайландаа тусгах тал дээр анхаарахыг тус тус зөвлөмж болгож байна.</p>					
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Европын холбооны санхүүжилттэй, НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “Ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл”-тэй үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж эхэллээ. Мөн ШХА-ын “Тогтвортой хөгжлийн боловсрол” (ТХБ) төсөлтэй хамтран эко сургуулиудын үйл ажиллагааг дэмжин ажилласан. Нийслэлийн засаг даргын даргын тамгын газрын холбогдох хэлтсүүдтэй хамтран Улаанбаатар хотын гэр хорооллын газар тариалангийн үйлдвэрлэл, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Хүнсний ногооны чиглэлээр гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг бусад гадаад, дотоодын төрийн ба төрийн бус тухайлбал, Дэлхийн зөн, АДРА, КАРИТАС, Глобал коммюнитис зэрэг байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан ажилласан.</p> <p>Төслийг хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.</p>					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтыг н тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	Тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	84.9 %	4	90.0 %	75.5 %	94.1 %	80.0 %
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)					Нэгдсэн үнэлгээ	

ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ “МОНГОЛ НОГОО” ТӨСЛИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Гарчиг

1.	ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
2.	ҮР ДҮН БА ГҮЙЦЭТГЭЛ.....	6
	Үр дүн: 1.1 Орон нутагт сайн чанарын баталгаатай үрийн олдоцтой болсон байна.....	6
	Үр дүн 1.2: Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна.....	8
	Үр дүн 1.3: Ногоочдын мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн байна.....	8
	Үр дүн 2.1: Маркетингийн (тариаланчдын бүлэг/хоршооллууд) хамтарсан үйл ажиллагааны суурь тавигдана.....	10
	Үр дүн 2.2: Маркетингийн сувгууд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд орно.....	11
	Үр дүн 2.3: Зах зээлийн оролцогч талууд зах зээлийн мэдээллийг авах боломжтой болсон байна.	11
	11	
	Үр дүн 2.4: Хүнсний ногоо боловсруулах санаачлагуудыг дэмжсэн байна.....	12
	Үр дүн: 3.1 Хот болон хот орчмын эмзэг, бүлгийн (ялангуяа өрх толгойлсон эмэгтэй) өрхүүдийн хүнсний ногоо тариалалт нэмэгдсэн байна.....	12
	Үр дүн 3.2: Хот болон хот орчмын бүсэд хүнсний ногооны хэрэглээ нэмэгдсэн байна.....	13
	Үр дүн 3.3: Эмзэг бүлгийн өрхүүд сургалтанд хамрагдаж, мэдлэг мэдээллээр хангагдсан байна.	14
	14	
	Үр дүн 4.1: Хүнсний ногооны өртгийн сүлжээнд мөрдөгдөх ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээ, ургамал хамгааллын цогц арга хэмжээ, органик хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулсан байна.....	14
	Үр дүн 4.2: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ, органик хөдөө аж ахуйн талаарх бодлого, эрх зүйн орчны талаар төрийн албан хаагчдыг мэдлэгжүүлж, чадавхижуулсан байна.....	16
	Үр дүн 4.3: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ, пестицид, органик үйлдвэрлэл зэрэгтэй холбогдсон эрх зүйн орчинг хэрэгжүүлэх ажлыг сумын түвшинд турших, тэдгээрийн үр дүнг баримтжуулах.....	16
3.	ЖЕНДЭР	18
4.	ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН УЯЛДАА ХОЛБОО.....	19
5.	СУРГАМЖ, ОЛӨЛТ АМЖИЛТУУД.....	19
6.	ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ.....	19
7.	САНХҮҮ, МЕНЕЖМЕНТ.....	20

ТОВЧЛОЛ

МХШТФХ	Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо
УГТХ	Ургамал, газар тариалангийн хүрээлэн (Дархан)
SECiM 2	Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх төсөл
Монгол Ногоо	Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төсөл
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
БОХХААБ	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
ОУБ	Олон Улсын Байгууллага
УХЦА	Ургамал хамгааллын цогц арга
ХББ	Хамтын баталгаажуулалтын байгууллага
МХЭАХНҮХ	Монголын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад Атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхт 60 жил 2019 онд тохиож салбарын хүрээнд олон үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Өнгөрсөн 60 жилийн хугацаанд Монгол Улс Атар 1, 2, 3-р аяныг зарлаж, амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар, буудай, төмсөөр дотоодын хэрэгцээгээ 100%, хүнсний ногооны 52%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангаад байна. Атрын 3-р аяны хүрээнд техникийн шинэчлэлд ихээхэн хөрөнгө оруулалт хийсний үр дүнд үр тарианы ургац хураах техникийн 85%, тракторын 75%, ХАА-н чиргүүл, дүүжин машины 65%-ийг тус тус шинэчилсэн бол энэ хугацаанд төмсний техникийн 52%-ийг, хүнсний ногооны техникийн дөнгөж 38%-ийг шинэчилээд байсан нь тун хангалтгүй үзүүлэлт бөгөөд цаашид энэ талаар онцгой анхаарах шаардлагатай байна.

2019 онд улсын хэмжээнд 14.8 мянган га-д төмс, 8.1 мянган га-д хүнсний ногооны тариалалт хийгдэж 12 сарын 30-ны байдлаар 191 мянган тонн төмс, 95 мянган тонн хүнсний ногоо хураан авчээ. Тариалангийн гол бүс нутгаар 6-р сарын сүүлч хүртэл хур бороогүй гантай байсан нь төмс, хүнсний ногооны ургац буурахад нөлөө үзүүллээ. Харин дулаахан урт намар болсон нь ургац хураалтыг чанартай бүрэн хийхэд таатай нөхцөл болсон.

НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Монгол ногоо” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг болох эрх зүйн орчныг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд “Таримал ургамлын үр сортын тухай” хуулийн шинэчлэн найруулсан төсөл 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр УИХ-д өргөн баригдаж тус хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхээр шийдвэрлэгдлээ. Мөн жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг ХХААХҮ-ийн болон Эрүүл мэндийн сайдууд хамтран баталлаа. Уг зааврыг ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэсэн.

Төслийн баримт бичигт тусгагдсаны дагуу Төслийн үндсэн үе шат 2016-2019 оны хугацаанд амжилттай хэрэгжиж дуусч байна. Төгсгөлийн үе шатын Төсөл үр дүнтэй хэрэгжиж байгаатай холбоотой төслийн үр дүнд бий болсон бүтэц, үйл ажиллагаануудын тогтвортой байдлыг хангахад голлон ажиллах төслийн төгсгөлийн үе шатыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг Швейцарын хөгжлийн агентлаг гаргасан болно. Үндсэн үе шат хагас жил /6 сар/ буюу 2020 оны 1 сарын 1 нээс 2020 оны 6 сарын 31 ээр сунгагдаж, төгсгөлийн шат 2020 оны 7 сарын 1 ээс эхлүүлэхээр товлогдлоо.

Хүснэгт 1: Улсын болон төсөлд хамрагдсан сумдын тариалалт, ургацын хэмжээ

	Он	Улсын хэмжээнд	Төсөл хэрэгжиж буй сумдад	Эзлэх хувь % Нэмэгдэл ургац
Тариалсан талбай /га/	2017	8,357	3,064	36.6
	2018	8,866	3,341	37.7
	2019	8,290	3,384	40.8
Хураасан ургац /тн/	2017	82,102	26,489	32.2
	2018	100,732	41,492	41.2
	2019	95,800	41,842	43.7
Нэгжийн ургац ц/га	2017	103.0	86.4	-16.6
	2018	118.0	124.1	+6.1
	2019	117.0	123.6	+6,6

Төслийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй Төвийн бүсийн 4 аймгийн 12 сумын хүнсний ногооны тариалалт улсын хэмжээний тариалалтын 36.8-40.8 хувийг эзлэж жил бүр өсөлттэй гарлаа. Хураан авсан хүнсний ногооны хувьд улсын хэмжээнд хураасан ургацын 32.2-43.7 хувийг эзэлж жил бүр өсөж байна. Эндээс дүгнэж үзэхэд “Монгол ногоо” төслийн хүрээнд үйлдвэрлэлд нэвтрүүлж нутагшуулсан ургац өндөртэй шинэ сортын үрээр хангах, ногоочдын технологийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын үр дүнгээр ногоо тариалах сонирхол, нэгжээс авах ургац нэмэгдэж байна. Харин 2017 онд төвийн бүсийн нутгаар хавар зуны хүчтэй ган болсон нь нэгжийн ургац буурахад нөлөөлжээ.

Хүснэгт 2: Монгол хүний хүнсний ногооны жилийн дундаж хэрэглээ 73 кг

Он	Тариалсан талбай га	Ургац тонн	Импорт Тонн	Нийт	Хүн ам	Нэг хүний жилийн дундаж хэрэглээ (кг)	Нэг хүнд ноогдох дотоодын үйлдвэрлэл (кг)
2015	7,656	72,348	40,729	113,076	3,057,778	40	26
2016	9,052	94,447	60,307	154,754	3,119,935	54	33
2017	8,357	82,102	58,117	140,219	3,177,899	48	28

2018	8,866	100,732	69,310	170,071	3,238,479	57	34
2019	8,290	95,800	59,535	155,335	3,300,000	51	32

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар

1. ҮР ДҮН БА ГҮЙЦЭТГЭЛ

Үр дүн: 1.1 Орон нутагт сайн чанарын баталгаатай үрийн олдоцтой болсон байна

Хүнсний ногооны сорт сорилт Монгол төмс хөтөлбөрийн Төгсгөлийн үе шатны үйл ажиллагааны үргэлжлэл болон 8 дахь жилдээ хүнсний ногооны сорт сорилтын ажлыг зохион байгуулан явуулж байна. 2019 онд хүнсний ногооны 3 зүйлийн 20 сортын үрийг Дарханы Ургамал Газар Тариалангийн Хүрээлэнд сорилтонд орууллаа.

1999 онд батлагдсан “Таримал ургамлын үр, сортын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Монгол Улсын Их Хуралд өргөн баригдаад байна. Уг хуулийн төсөлд таримал ургамлын үр, сортын бодлогын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үрийн технологийн нөөц бүрдүүлэх, ургамлын шинэ сортыг сорих, турших, бүртгэх, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага хариуцан гүйцэтгэхээр тусгасан. Харин эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, аймаг, нийслэлд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагын газар тариалангийн нэгж, сум, дүүрэгт таримал ургамлын үр сорт, газар тариалангийн үйлдвэрлэлийн технологийн асуудал хариуцсан албан хаагч, тариалангийн бүс дэх сорт сорилтын үйл ажиллагаа эрхлэх төв хариуцан гүйцэтгэхээр хуулийн төсөлд тусгасан байна.

Энэхүү ажлын үр дүнд цаашид сорт сорилтын ажлыг тогтвортой хэрэгжүүлэн явуулах бүтэц, зохион байгуулалтын хууль эрхзүйн орчин бүрдэнэ.

2019 онд Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яамны (ХХААХҮЯ) Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтэс шинээр байгуулагдаж орон тооны 3 мэргэжилтэнтэйгээр ажиллаж эхэлсэн байна.

2019 онд Улсын сорт сорилтын зөвлөл хуралдаж, бууцайны Матадор болон цэсний Чёрная красавица сортууд нутагшсан сортоор батлагдлаа. Ийнхүү голлох нэр төрлийн хүнсний ногооны хувьд 12 нутагшсан, 14 ирээдүйтэй сорт, 13 эрлийз ирээдүйтэй сорт шинээр батлагдаад байна.

1968-2019 онд Монгол улсад нийт 39 зүйл хүнсний ногооны таримлын 79 сорт нутагшсан болон ирээдүйтэйгээр батлагдсаны 39 буюу 49 % нь Монгол төмс хөтөлбөр болон Монгол ногоо төслийн хүрээнд туршигдаж, бүртгэгдсэн байна.

Хүнсний ногооны үр үйлдвэрлэл

Эрлийз сорт: 2019 онд тариаланчдын гаргасан хүсэлтийн дагуу эрлийз сортуудын үр нийлүүлсэн.

2019 онд 317 га талбайд байцаа, хүлэмжийн өргөст хэмх, талбайн өргөст хэмх, хүлэмжийн улаан лоолийн эрлийз сортын үрийг төслийн дэмжлэгийн хүрээнд тариалжээ. (Хүснэгт 3)

Хүснэгт 3: Эрлийз сортуудын үрийн нийлүүлэлт

#	Таримал	2016 он	2017 он	2018	2019
1	Байцаа (Hurricane F1)	28 га	228 га	285 га	240 га
2	Хүлэмжийн өргөст хэмх (Saladin F1)	1,4 га	2,7 га	5,1 га	2,3 га
3	Талбайн өргөст хэмх (Elisa F1)		0,7 га	2,3 га	65 га
4	Хүлэмжийн улаан лооль (Tolstoi F1)	4,8 га	8,2 га	24,6 га	9,4 га

Эрлийз үр нь үнэ өндөртэй байдаг тул худалдан авч, тарих санхүүгийн боломж муутай тариаланчдад төслийн хүрээнд туршигдаж, батлагдсан, сайн чанарын шинэ эрлийз сортын үр хөнгөлөлттэй үнээр хүрч байгаа нь цаашид тариаланчид эрлийз сортын үрийн давуу талыг мэдрэх, шинэ технологийг хэвшүүлэхэд дөхөм болох юм.

Хүнсний ногооны үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдон ХХААХҮЯ-наас “Ил талбайн ногооны үр худалдан авах” нийт 100 сая төгрөгийн төсөвтэй 7 төрлийн үр худалдан авах тендер зарласан бөгөөд үүнээс Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо ТББ нь (МХШТФХ) Увс аймагт үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан шар лууван, шар манжин, хүрэн манжингийн нутагшсан сортын нийт 50 сая төгрөгийн үнэ бүхий 1,886 кг үр нийлүүлсэн бөгөөд уг үрийг ХХААХҮЯ аймаг, сумдад хуваарилан олгов.

Үүнээс гадна Азийн Хөгжлийн Банкны (АХБ) санхүүжилттэй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах” төсөл, АДРА ОУБ-ын “Органик ХАА-н түншлэл” төсөл, НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын “Secim Нэмүү өртгийн сүлжээ” төсөл зэрэг хөдөө аж ахуй, хүнсний ногооны чиглэлээр хэрэгжиж байгаа бусад төсөл, хөтөлбөрүүд мөн холбооны гишүүд болон төсөл хэрэгжиж буй сумдын ногоочдод 395.0 сая төгрөгийн үнэ бүхий нийт 6,147 кг хүнсний ногооны үрийг Үрийн нөөц сангаас худалдсан байна.

Сүүлийн үед шинээр ирээдүйтэй сортоор батлагдсан үндэс үртэн болон байцааны шинэ сортын үрийг Увс аймагт, тарвас, амтат гуа, улаан лоолийн үр үржүүлэг Ховд, Дорноговь, Баянхонгор аймгуудад тус тус явагдаж байна. Бага тархацтай ногооны зарим шинээр батлагдсан ирээдүйтэй сортуудын үрийг мөн Ургамал Газар Тариалангийн Хүрээлэнгийн (УГТХ) ногооны үр үйлдвэрлэлийн талбар дээр үржүүлж байна. Төслөөс үр үржүүлгийн ажлыг дэмжиж 2018 онд УГТХ-ийн үйлдвэрлэсэн 3 зүйл хүнсний ногооны 3 сортын 87 кг элит үрийг МХШТФХ-ны дэргэдэх Үрийн нөөц сангаар дамжуулан борлууллаа.

Хүнсний ногооны үрийн нөөц сан МХШТФХ-ны дэргэдэх уг сан 2019 оны хаврын тариалалтанд зориулж хүнсний ногооны 17 зүйл, 26 сортын 6,147 кг үрийг 21 аймаг дахь салбар холбоо, 5 үрийн жижиглэн борлуулагчдаар дамжуулан түгээсэн. Аймгууд дахь салбар холбоодын гишүүн ба гишүүн бус ногоочид, жижиг өрхийн тариаланчдад үр нийлүүлэгч, дистрибуторын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Үрийн нөөц сан нь хөдөө орон нутаг, алслагдсан бүсийн ногоочид, тариаланчдад үндсэн нэр төрлийн хүнсний ногооны үрийг бөөний үнээр нийлүүлэхэд зорин ажиллаж байна. Ийнхүү хүнсний ногооны үрийн чанар болон гарал үүслийг улсын түвшинд хянах боломж бүрдэж байгаа юм.

Хүснэгт 4: Хүнсний ногооны үрийн нөөц сангийн үрийн түгээлт

Төрөл	2017 он	2018 он	2019 он
Таримлын зүйл /ширхэг/	12	13	17
Сорт /ширхэг/	15	20	23
Нийлүүлсэн үр /кг/	2,864	7,182	6,147
Нийлүүлсэн аймаг /тоо/	21	21	21
Жижиглэн борлуулагч /тоо/	5	4	5

Хүнсний ногооны үрийн нөөц сангийн бизнес төлөвлөгөө 2020 оноос эхлэн үрийн нөөц сан төслийн дэмжлэггүйгээр бие даан үйл ажиллагаагаа явуулах тул оролцогч талуудын үүрэг оролцоо тодорхой мөн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий бизнес төлөвлөгөөтэй байх зайлшгүй шаардлагатай. Тиймээс төсөл бие даасан зөвлөлтэй гэрээлэн үрийн сангийн бизнес төлөвлөгөө боловсруулсан. Харин Швейцарын Хөгжлийн Агентлагын (ШХА) зүгээс тус бизнес төлөвлөгөөг дахин сайжруулах нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн. Мөн ШХА-ын захиалгаар үрийн санд хараат бус хөндлөнгийн аудит хийлгэсэн. Аудитын дүгнэлт тайланд үндэслэн бизнес төлөвлөгөөг дахин боловсруулахаар боллоо.

Талбайн хянан баталгаа 8-р сард мэргэшсэн 2 талбайн хянан батлагч нар МХШТФХ-ны Увс аймаг дахь салбар холбооны гишүүн 35 үр үржүүлэгчдийн талбараар явж, хянан баталгаа хийлээ.

Үүний зэрэгцээ Увс аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч, Хөдөө аж ахуйн газрын агрономч зэрэг залуу мэргэжилтнүүдийг дагалдуулж, дадлагажуулав. Үр үржүүлэгчид мөн үрийн чанарыг сайжруулах, цаашид анхаарах зүйл, өөрийн үрийн талбай дээр зөвлөгөө авлаа.

Талбайн хянан батлагчийн үнэмлэхтэй мэргэжилтэн нийт дөрөв бэлтгэгдсэн байгаа бөгөөд энэ жил ВНИИССОК хүрээлэнгээс зөвлөхүүд ирж талбайн хянан баталгааны явцтай танилцаж, ногооны үр үржүүлгийн талбар тус бүр дээр хянан батлагч болон үр үйлдвэрлэгч ногоочдод мэргэжлийн зөвлөгөө өгсөн.

Саримсны үр үйлдвэрлэл 2017 оноос УГТХ болон Завхан аймгийн МХШТФХ-ны салбартай хамтран улаан хальст саримсны нутагшсан сортын, стандартын шаардлага хангасан үрийн сармис ургуулах, хүнсний ногооны үр үржүүлэгч нарын үрийн сармисны үйлдвэрлэлийг дэмжих, үрийн материалыг эрүүлжүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна. 2019 онд Дорнод аймгийн Баянтүмэн суманд 3 жил тарьж туршигдсан Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хянган мужийн нутгийн цагаан хальст сармисны 2 тонн үрийн саримс импортлон ногоочид, өрхийн тариаланчдын үрийн хэрэгцээнд нийлүүлж үүний 500 кг-ыг 5 аймгийн саримсны үйлдвэрлэл түлхүү эрхэлдэг 7 сумдын салбар холбоодод 2 дахин үржүүлж төсөлд нийлүүлэх үр үржүүлгийн гэрээгээр олгов.

Ингэснээр саримсны тариалалт 4 га-гаар нэмэгдэж, ойролцоогоор 32 тонн саримс үйлдвэрлэх боломж бүрдсэн. Энэ нь улсын хэмжээнд саримсны үйлдвэрлэл 7.5 хувиар нэмэгдэх боломжтой болжээ. Мөн үрийн материалыг ашиглан цаашид саримсны үрийг шинэчилж, эрүүлжүүлснээр ургац, үйлдвэрлэл нь нэмэгдэн, тариаланчдын бүтээмж, үр ашиг нь дээшилнэ.

Саримсны тариалалтыг хөнгөвчлөх, зардлыг хэмнэх үүднээс саримсны гар үрлэгчийг үйлдвэрлэл дээр туршихаар авсан ба, цаашид саримсны хумс хальслагч зэрэг тоног төхөөрөмжийг нэмж туршихаар төлөвлөд байна.

Хүнсний ногооны стандартууд шинээр боловсруулах, шинэчлэх 2018 онд Стандарт, хэмжилт зүйн үндэсний зөвлөлийн тогтоолд дурдсаны дагуу төслөөс хүнсний ногооны 8 стандартын төсөл шинээр боловсруулах, 18 стандарт шинэчлэх ажлыг зохион байгуулж, техникийн хороогоор хэлэлцэн батлах шатандаа явж байна. 2019 онд “Хүнсний ногоон дахь пиретроидын

бүлгийн пестицидийн үлдэгдлийг зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг илрүүлэх түргэвчилсэн тестийн арга” шинжилгээний стандарт шинээр боловсруулах, Төмс, хүнсний ногоо хадгалах MNS 3024:81 стандартыг шинэчлэх ажлын хэсгүүд томилогдон ажиллалаа. Үүний үр дүнд таримлын пестицидийн үлдэгдлийг түргэвчлэн илрүүлэх замаар хүнсний аюулгүй байдалд тавигдах хяналт сайжирна.

Дээрх стандарт боловсрогдон гарч байгаатай холбоотой түргэвчилсэн тестийн иж 22 бүрдлийг оруулж ирлээ. Хүнсний химийн чиглэлээр итгэмжлэгдсэн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын лаборатори, зарим аймаг, сумдын агрономи зэрэг хүнсний аюулгүй байдлыг хангаж, хэрэглэгчдийг аюулгүй хүнсээр хангахад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, дотоод хяналтын хүрээнд энэхүү оношлуураар ургамлын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдалд хяналт тавьж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхгүй байх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Өнөөдрийн байдлаар пестицидийн үлдэгдлийг зөвхөн Улаанбаатар хотод байрлах 1-2 төв лабораторт нэг дээжинд өндөр мэдрэгчтэй масс детекторын аргаар 27 мянган төгрөгөөр хийлгэдэг. Харин дээрх оношлуурын арга нь нэг дээжийг оношлоход 4 мянган төгрөг буюу хэд дахин хямд өртөгтэй мөн лабораторын бус аль ч нөхцөлд хэрэглэж болохоор давуу талтайгаараа онцлогтой юм.

“Байцаа, сонгины талбайд зарим хөнөөлт организмын хөнөөлийн босгыг тогтоох” сэдэвт судалгааны ажил, Ургамал Хамгаалал Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (УХЭШХ) Байцааны хөнөөлт шавж болох хивэн эрвээхэй, цагаан эрвээхэй, байцаа, сонгины талбайн 3 зүйлийн хог ургамал болон байцааны нэг өвчний “хөнөөлийн эдийн засгийн босго”-ыг (тухайн бүс нутаг, талбайд хөнөөлт организмын тархалтын түвшинг үнэлэн ургамал хамгаалах арга хэмжээг эдийн засгийн хувьд зүйд нийцүүлэн явуулахыг хэлдэг) судласан. Энэхүү судалгааны үр дүнг ойрын 5 жилд байцааны хөнөөлт зарим организмтай тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой боллоо. Үүний үр дүнд байцааны нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, тариаланчдын эдийн засгийн ашиг нэмэгдэнэ.

Үр дүн 1.2: Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

Өрхийн тариаланчид, ногоочдод хүлэмжийн ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 120 м²-ийн хүлэмж 7 ширхэг, 32 м²-ийн хүлэмж 26 ширхэг (нийт 1,672 м²)-ийг 10 аймгийн 12 сумын тариаланчдад нийлүүлсэн. 2019 онд мөн төслийн үр шим хүртэгчдийн хувь оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хүлэмжийн үнийн дүнгийн 20%-ийг тариаланчид өөрсдөө санхүүжүүлэв. Тариаланчдад мөн эрдэс бордоо, сайн чанарын ургамал хамгааллын шинэ бодисыг хуваарилан олгов.

Хүнсний ногооны үйлдвэрлэл үр тариа болон төмсний үйлдвэрлэлтэй харьцуулахад механикжуулалтын түвшин хамгийн бага хувьтай (40%) гар ажиллагаа давамгайлсан байдаг. Хүнсний ногооны үйлдвэрлэлд дунд, том оврын техникээс илүү бага оврын эсвэл гар ажиллагаатай техник илүү тохиромжтой байдаг нь ихэнх хүнсний ногоо тариалдаг талбай бага хэмжээтэй, голын хөндий дагуу байрласан суваг, шуудуугаар хязгаарлагдан эргэлтийн зурвасгүй байдагтай холбоотой.

Төслийн зүгээс автомат үүргэвчин хор шүршигч, автомат үүргэвчин сийрүүлүүр, саримсны гар үрлэгч зэрэг бага оврын тоног төхөөрөмжийг Төв, Сэлэнгэ болон аймгийн хэмжээнд газар тариалангийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй Ховд, Увс зэрэг аймгийн хүнсний ногоо тариалагчдад нийлүүллээ.

Цаашид сонгины дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд дотооддоо төл сонгино үйлдвэрлэх төрөлжсөн аж ахуй байгуулах, импортын төл сонгиныг гаалийн татварын хөнгөлөлтөнд хамруулах талаарх саналаа ХХААХҮЯ, Ерөнхий сайдад танилцуулаад байна.

Хүснэгт 5: Тараасан тоног төхөөрөмж

	Тоног төхөөрөмж, хүлэмж	Тоо	Үйлдвэрлэгч	Үнийн дүн
1	Саримсны түрдэг гар үрлэгч GP-1	5	Хятад	4.5 сая
2	Сонгины ухагч Z653/1, 1.5м	3	Польш	45 сая
3	Сонгины үрлэгч S287/5 мөрний	3	Польш	27.8 сая
4	2 мөрний манагч, сийрүүлэгч P475	3	Польш	3.8 сая
5	4 мөрний манагч, сийрүүлэгч P475/1	3	Польш	5.2 сая
6	Нийлэг хальсан хүлэмж 4x8м	26	БНХАУ	32.5 сая
7	Нийлэг хальсан хүлэмж 6x20м	7	Солонгос	25.6 сая
	Дүн	50		144.4 сая

Үр дүн 1.3: Ногоочдын мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн байна.

Экстейншин төв 2016-2017 онд Дархан-Уул аймгийн Орхон сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур сумдад загвар экстейншин төв, 2018 онд Төв аймгийн Зуунмод хотод “Атрын шим” хүлэмжийн аж ахуйг түшиглэн “Хүлэмжийн экстейншин төв” байгуулагдахад дэмжлэг үзүүллээ. Эдгээр загвар экстейншин төвүүд нь туршилтын талбайдаа хүнсний ногооны шинэ төрөл

зүйлийн болон сортын сорилт, УХЭШХ-тэй хамтарсан шинэ ургамал хамгааллын бодис турших судалгааны ажил үзүүлэнгийн талбар дээр хийхээс гадна бага оврын техникийн түрээс, үр, УХБ-ын борлуулалт, сар тутам ногоочдын хүсэлтийн дагуу технологийн сургалтуудыг зохион байгуулж байна.

Хүснэгт 6: 2019 оны Экстейншин төвүүдийн үйл ажиллагааны тайлан

Экстейншин үйл ажиллагаа	Тариалалт, үзүүлэнгийн талбар	Бага оврын тоног төхөөрөмжийн түрээс	Үр, ургамал хамгааллын бодис, бордооны борлуулалт	Сургалт, талбайн өдөрлөг	Санхүүгийн тайлан
Дархан-Уул, Орхон суман дахь Экстейншин төв	1 га /9 зүйл хүнсний ногооны 9 сорт/	43,7 га /трактор, роторт сийрүүлэгч, мөр хоорондын сирүүлэгч/	Үр – 376 кг, УХБ – 5 л, Бордоо – 100 л	1 удаагийн сургалт 36 ногоочин	Үйл ажиллагааны орлого – 24 сая төг, Төслөөс үзүүлсэн санхүүжилт – 7,5 сая төгрөг
Сэлэнгэ, Мандал суман дахь Экстейншин төв	1.5 га /4 зүйл хүнсний ногооны 5 сорт/	10.5 га /х/н-ны үрлэгч, байцааны үрслэг суулгагч, ургамал хамгааллын бодис шүршигч, бордоо цацагч/	Үр – 41 кг, УХБ – 65 л, Бордоо – 1300 кг	2 удаагийн сургалт 37 ногоочин	Үйл ажиллагааны орлого – 1,9 сая төг Төслөөс үзүүлсэн санхүүжилт – 7,5 сая төгрөг
Төв, Борнуур суман дахь Экстейншин төв	0.6 га /3 зүйл хүнсний ногооны 4 сорт/	52,6 га /байцааны үрслэг суулгагч, ургамал хамгааллын бодис шүршигч, роторт сийрүүлэгч/	Үр – 303 кг, УХБ – 132 л, Бордоо – 693 кг	4 удаагийн сургалт 150 ногоочин	Үйл ажиллагааны орлого – 11,8 сая төг Төслөөс үзүүлсэн санхүүжилт – 7,8 сая төгрөг
Дорнод, Зүүн бүсийн Экстейншин төв	-	3 га /хор шүршигч/	Үр – 34 кг, Бордоо – 20 л	2 удаагийн сургалт 45 ногоочин	Төслөөс үзүүлсэн санхүүжилт – 850 мянган төгрөг

Хөдөө аж ахуйн зохистой дадлыг (ХААЗД)-ыг Монгол улсад нэвтрүүлэх, баталгаажуулах “Эс Эф Си Эс” ХХК болон НҮБ ХХААБ-ын хэрэгжүүлж буй Хууль эрх зүйн 4-р бүрэлдэхүүн хэсэгтэй хамтран ХААЗД-ын стандартыг хүнсний ногооны тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, баталгаажуулах туршилтыг хийх, ХААЗД-ын баталгаажуулалтын үндэсний тогтолцоо бий болгох, ХААЗД-ын баталгаажуулалт хийлгэхэд хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж ажилласан. Энэ ажлын хүрээнд:

- 1) ХААЗД-ын баталгаажуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэх аудиторуд болон ХААЗД нэвтрүүлэхээр зорьж байгаа тариаланчдад зөвөлгөө өгөх үүрэг бүхий зөвлөхүүдийг сургалтаар бэлтгэлээ. Энэ үйл ажиллагаа нь манай улсад ХААЗД-ын баталгаажуулалтын тогтолцоо шинээр бүрдэхэд хувь нэмэр болж байна.
- 2) “Атрын шим” болон “Сэмжит Оюу” ХХК хүлэмжийн хоёр аж ахуйн нэгж дээр ХААЗД-ын баталгаажуулалтыг хийлгэхэд дэмжлэг үзүүлэн, амжилттай баталгаажуулалт хийгдлээ.

Гарын авлага, хэвлэмэл материал Хүнсний ногооны сортын каталогийг хэвлүүлэв. Энд багтсан нийт сортын 49 % нь Монгол төмс хөтөлбөр болон Монгол ногоо төслийн хүрээнд туршигдаж, бүртгэгдсэн байна. Ургамал хамгааллын заавар, аюулгүй ажиллагааны талаар гарын авлага хэвлэн гаргасан. Талбайн түүхийн дэвтрийг ХААЗД-ын шаардлагын дагуу засаж өөрчлөн, хэвлүүлсэн. Монгол улсад атар газар эзэмшиж газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойд тохиолдуулан 1969 онд боловсруулсан “Монгол улсын газар тариалан эрхлэх систем”-ийг шинэчлэн боловсруулах багийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Зөв зохистой хооллолт, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх сэдвээр тус бүр нь 3 минутын 10 цуврал видео контентийг Оюундарь хоолны зөвлөх болон “Монголын органик ногоон хүнсний холбоо” ТББ-той хамтран хийж байна.


“Бүрэлдэхүүн хэсэг-1”-ийн үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээ

№	Үр дүнгийн үзүүлэлтүүд	Суурь 2016	Төлөвлөсөн 2019	Гүйцэтгэл 2019	Хувь
1	Шинээр албан ёсоор батлагдсан сортын тоо	5	20	14	70%
2	Зорилтот бүсийн хүнсний ногоо тариалах талбайн хэмжээ (га)	2,708	>20%	3,384 (25%)	100%
3	Зорилтот бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэл (тн)	25,591	>20%	41,842 (63%)	100%
		Бүтээгдэхүүн 1-ХШҮ			90.0%

Үр дүн 2.1: Маркетингийн (тариаланчдын бүлэг/хоршоолууд) хамтарсан үйл ажиллагааны суурь тавигдана.

Борлуулалтын хоршоо 2018 онд Төв аймгийн Борнуур, Жаргалант, Батсүмбэр мөн Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Хушаат сумын 120 гаруй ногоочдын санаачлагаар “Цэвэр хөрсний шим” дундын хоршоо үүсгэн байгуулагдсан. Хоршоо нь гарал үүсэл тодорхой, шинжилгээний бичгээр баталгаажсан төмс, хүнсний ногоог гэрээт үйлдвэрлэлийн зарчмаар сүлжээ дэлгүүр, нийтийн хоолны газар зэрэг 5 аж ахуйн нэгж, байгууллагын 17 салбарт нийлүүлж байна. 2019 оны 11 сарын байдлаар 460 сая төгрөгийн борлуулалт буюу нийт 363 тонн ногоог нийлүүлжээ. **Үүний үр дүнд ногоочдын ашиг 20% иар нэмэгдэж байна.**

График 1: Дундын хоршооны хүнсний ногооны борлуулалт /2019 оны 11 сарын 30 байдлаар/



Зохион байгуулалтанд орсон ногоочид зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд тулгардаг түгээмэл бэрхшээлүүдийн нэг нь зоорины асуудал байдаг. Дээрх графикаас харахад 2019 оны 6-р сард бусад саруудаас бага буюу 15 тонн хүнсний ногоо борлуулсан нь тухайн сард хүнсний ногооны нөөц дууссантай холбоотой байна. Энэ нь зоорины хангамж муу байдагтай холбоотой юм. Зоорины хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2019 онд нийт 1,160 тонны багтаамж бүхий хүнсний ногооны 12 зоорийг 7 суманд байгуулагдахад төсөл дэмжлэг үзүүлсэн. Мөн 2019 онд Улаанбаатар хотод 600 тонны багтаамжтай нөөцийн зоорь буюу дамжуулан борлуулах төв байгуулагдахад төслөөс дэмжлэг үзүүллээ. **Үүний үр дүнд орон нутгаас тээвэрлэн ирсэн хүнсний ногоог харилцагч байгууллагын захиалгын дагуу тогтмол хугацаанд, гэрээлсэн хэмжээгээр, тасралтгүй нийлүүлэх мөн хүнсний ногоог савлан сүлжээ дэлгүүрүүдэд түгээх боломж бүрдсэн.** Хүснэгт 7: Шинэчлэгдсэн болон шинээр байгуулагдсан зоорь

#	Байршил	Зориулалт	2017-2019 он
1	Төв аймаг, “Атрын шим” ХХК	Хүлэмжийн ногоо	20
2	Төв аймаг, Жаргалант сум, “Дэлгэр Уянга” ХХК	Байцаа	340
3	Төв аймаг, Батсүмбэр сум, “Сөгнөгөрийн хишиг” хоршоо	Сонгино	100
4	Төв аймаг, Жаргалант сум, “Жаргалант арвин ургац” хоршоо	Төмс, ногоо	150
5	Сэлэнгэ аймаг, Шаамар сум, “Саримсны үр үржүүлэг” хоршоо	Саримс, сонгино	100
6	Сэлэнгэ аймаг, Хушаат сум, “Эко хушаат” хоршоо	Сонгино	50
7	Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сум, “Улам бадрах өсөн дэвжих” хоршоо	Саримс	20
8	Орхон аймаг, Жаргалант сум, “БЛГЯ” хоршоо	Байцаа	50 80
9	Орхон аймаг, Жаргалант сум, “Шонхорын хүч” хоршоо	Байцаа	200
10	Ховд аймаг, Усалгаатай тариалан эрхлэгчдийн холбоо	Сонгино, саримс	150
11	Улаанбаатар хот, “Цэвэр хөрсний шим” дундын хоршоо	Дамжуулан борлуулах төв	600
	НИЙТ /тонн/		1,760

Дундын хоршоо нь гэрээт үйлдвэрлэлээр дамжуулан хүнсний ногооны үнэ болон хангамжийг тогтвортой хадгалахад анхаарч байна.

Үр дүн 2.2: Маркетингийн сувгууд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд орно.



Улаанбаатар хотын төмс, хүнсний ногооны бөөний зах Улаанбаатар хотын хүн амыг эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр жилийн турш найдвартай, тогтвортой хангах, ногоочдыг борлуулалтаар дэмжих 10 га талбай бүхий хадгалалт, борлуулалтын төв 2020-2021 онд байгуулагдахаар төлөвлөгдсөн. Энэ ажлын хүрээнд төсөл нь тариаланчдыг тус бөөний төвийн үйл ажиллагаанд зохион байгуулалттай оролцох нөхцийг урьдчилан бүрдүүлж, чадавхжуулах чиглэлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус зах байгуулагдах үед ногоочдын байгуулсан дундын хоршоо нь ногоочдыг борлуулалтаар дэмжих үйл ажиллагаанд менежментийн болон дилерийн үүргийг гүйцэтгэх юм. Өнөөдрийн хийгдэж буй дундын хоршооны ажлууд олон талаараа дээрх зорилготой нийцэж байна.

Үр дүн 2.3: Зах зээлийн оролцогч талууд зах зээлийн мэдээллийг авах боломжтой болсон байна.

Вэб хуудас МХШТФХ-ны www.mfard.mn цахим хуудас шинэчлэгдлээ. Цахим хуудасны агуулга болон загвар дизайныг өөрсдийн хүссэнээр хөгжүүлэх мөн хямд зардлаар ашиглах боломжтой платформ боллоо. Монгол ногоо төслийн хэрэгжүүлж буй ажлуудыг цахим хуудсанд тогтмол нийтэлж байгаа бөгөөд нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна. Цаашид тус цахим хуудсаар Хөдөө аж ахуйн зохистой дадал стандарт нэвтрүүлсэн байгууллагуудын жагсаалтыг албан ёсны эрхтэйгээр олон нийтэд хүргэх мөн хүнсний ногоо болон үрийн онлайн захиалга авах, бүртгэл хийх чиглэлд хөгжүүлэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Нийгмийн сүлжээ Төсөл нь “Монгол ногоо төсөл - MON VEGI project” 30,258 дагагчтай фэйсбүүк хуудсаар дамжуулан нийт 12 мэдээ, мэдээлэл болон бичлэгийг олон нийтэд түгээсэн байна. Мөн youtube сувагт 53 видео байршуулжээ.

Хүнсний ногооны үнэ, ханшийн мэдээлэл: Төмс, хүнсний ногоо борлуулах гэрээ байгуулахад томоохон хүнсний дэлгүүр болон захуудын үнэ ханшийн мэдээ чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс хараат бус хөндлөнгийн байгууллагаар жишиг үнийг гаргах бодлогыг баримтлан судалгааны мэргэшсэн байгууллагатай хамтран ажиллаж байна. Долоо хоног тутам томоохон зах, хүнсний дэлгүүрээр борлуулагдаж буй төмс хүнсний ногооны дундаж үнийн мэдээллийг олон нийтэд www.mfard.mn вэб холбоосоор дамжуулан 7 хоног тутам тогтмол хүргэж байна.

Хүнсний ногооны маркетинг, зах зээлийн форум “Хүнсний ногооны зах зээлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, гэрээт үйлдвэрлэлийн ач холбогдлыг таниулах, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааны суурийг тавих” зорилгоор Борлуулалтаа шийдье! уриан дор Маркетингийн форумыг 4 дэх жилдээ зохион байгууллаа. Тус форумд хүнсний үйлдвэр, томоохон сүлжээ дэлгүүр, мэргэжлийн холбоо, хоол үйлдвэрлэлийн компани мөн аймаг, сумын агрономич, тариаланчдын төлөөлөл болсон 100 гаруй оролцогч хамрагдлаа. Энэ удаагийн форумаар улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй худалдан авалт мөн хүнсний ногооны салбарын зохицуулалт зэрэг чиглэлээр мэдээлэл өгч, санал солилцов.

Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа Намрын ногоон өдрүүд арга хэмжээ 12 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Төслөөс тус үзэсгэлэн худалдаанд борлуулалтын 9 асрыг байрлуулан 6 аймгийн 10 сумын 30 гаруй ногоочдыг хамруулав. Ногоочид нийт тариалсан ногооныхоо 20-30%-ийг үзэсгэлэн худалдаагаар дамжуулан борлуулдаг тул энэхүү үзэсгэлэн худалдаанд ихээхэн ач холбогдол өгч жил бүр идэвхитэй оролцдог.

Нийслэлийн хөдөө аж ахуйн газар болон 4 дүүргийн худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран нийслэл хотын 25 байршил бүхий ил талбайн хүнсний ногооны үзэсгэлэн худалдааны бүртгэлийг онлайнгаар хийж байхаар боллоо. Энэ нь олон нийт болон хэрэглэгчдэд мэдээлэл хурдан шуурхай, ил тод очихоос гадна тайлан бүртгэл бодитой хийгдэх боломжийг бүрдүүлнэ.

Үр дүн 2.4: Хүнсний ногоо боловсруулах санаачлагуудыг дэмжсэн байна.

Хүнсний ногоо дахин боловсруулах цех Хүнсний ногоог дахин боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор орон нутагт хүнсний ногоо дахин боловсруулах цех, ажлын байр засварлах, үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах шаардлага болон тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтууд хийгдсэн байна. 2019 оны байдлаар орон нутагт нийт 7 цех ашиглалтанд орсноор 30 гаруй ажлын байр бий болох боломж бүрдлээ. **Эдгээр цехүүд 2019 онд 8,000 орчим ширхэг шилэнд нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 200 кг ногоо хатааж зах зээлд борлуулсанаар нийт 26 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.** Тухайн орон нутагт түгээмэл тариалдаг хүнсний ногоогоор өвөрмөц амт чанар бүхий брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд гаргах бүрэн боломж байгаа нь шарсан байцаа, даршилсан сонгино гэх мэт бүтээгдэхүүнийг хатаасан ногоотой хослуулан зах зээлд гаргаж байгаа цехүүдийн жишээнээс харагдаж байна. Тариаланчдын хувьд орон нутаг дахь үйлдвэрлэлийн чадавхи сайжирч байгаа ч маркетинг, худалдааны системд оролцох ур чадвар дутмаг байна. Энэ байдлыг сайжруулахын тулд цаашид дараах чиглэлд анхаарах хэрэгтэй. Үүнд: Бизнесийн ур чадварыг бэхжүүлэхэд сургалт, зөвлөх үйлчилгээг системтэй олгох, цехийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд гарааны үед нь хаяг шошго хэвлүүлэх, шил савны зардалд дэмжлэг үзүүлэх, цехийн үйл ажиллагааг бизнесийн зарчимд оруулахад дундын хоршооны борлуулалтын сувгийг үр дүнтэй ашиглах зэрэг болно.

Хүнсний ногооны хэрэглээг дэмжих зорилготой сургалт зохион байгуулав Монгол Улсын 21 аймгийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагддаг хүүхдүүдийн хоолны шим тэжээл, эрүүл мэндийн байдлыг хүнсний ногоогоор дамжуулан сайжруулах зорилгоор “Хүүхдийн хооллолт ба эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд Нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчийн цэцэрлэгийн 231 тогооч, Сэлэнгэ, Ховд, Завхан, Увс аймгийн 265 цэцэрлэгийн тогоочид буюу нийт 491 тогооч хамрагдлаа. **Үүний үр дүнд цэцэрлэгийн хоолны цэс шинээр 4-10 аар нэмэгдэх боломжтой боллоо.**

“Бүрэлдэхүүн хэсэг-2”-ын үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээ

№	Үр дүнгийн үзүүлэлтүүд	2019 оны байдлаар		
		Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
1	Зорилтот өрх бүрийн хүнсний ногооноос олох жилийн дундаж орлого	(Жилд 250,000 <) 500,000	2,840,467 272%	100 %
2	Хоршооллоор дамжуулж зарсан хүнсний ногооны хувь	(Жилд- 7,5% <) 30%	5 %	66.7 %
3	Хоршоолол, хувийн хэвшлийн хооронд зурагдсан идэвхтэй гэрээний тоо	(Жилд- 4 хүртэл гэрээ) 10	6	60.0 %
	Дундаж			75.5 %

Үр дүн: 3.1 Хот болон хот орчмын эмзэг, бүлгийн (ялангуяа өрх толгойлсон эмэгтэй) өрхүүдийн хүнсний ногоо тариалалт нэмэгдсэн байна.

“Жишиг гудамж” 2016 оноос төсөл хэрэгжиж эхлэснээс хойш нийт 17 жишиг гудамж бүхий 330 өрх хамрагдан үр шим хүртэж байна. 2019 онд хөдөө орон нутагт 4 шинэ жишиг гудамжийг дэмжин ажиллалаа. Энэ онд шинээр жишиг гудамжинд хамрагдсан 90 өрх нийт 6,301м² ил талбайд, 21 өрх 32м² хэмжээтэй хүлэмжийн 672м² талбайд тариалалт хийсэн бөгөөд нийт 6,976м² талбайд 13 төрлийн хүнсний ногооны тариалалт хийлээ.

Жишиг гудамжны (2014-2019 он) нийт үр шим хүртэгчид 40,171м² буюу 4,0 га талбайд тариалалт хийсэн нь өмнөх оноос 14,144м² буюу 35%-иар өссөн үзүүлэлт юм. 2019 онд жишиг гудамжны үр шим хүртэгчид зориулж 128 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэний 54% буюу 69 сая төгрөг төслөөс, 41% буюу 52 сая төгрөг орон нутгаас, 5% буюу 6 сая төгрөг үр шим хүртэгчдээс гарчээ. Жишиг гудамжны загварыг үр дүн сайтай гэж үзэн Мөрөн сумын орон нутгийн удирдлагаас гүний худгийн зардлыг бүрэн шийдвэрлэсэн нь томоохон дэмжлэг боллоо. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын удирдлагууд халамжийн үйлчилгээнд хамрагддаг 20 өрхөд шинээр хашааны газар олгож төсөлтэй хамтран гүний худаг гаргаж нэг жишиг гудамжийг нэмж байгууллаа.

Хүснэгт 8: Үр шим хүртэгчдийн 2019 онд тариалсан талбайн хэмжээ болон ургац

Зорилтот бүлэг		Тариалсан талбайн хэмжээ /кв.метр/				Хураан авсан ургац /кг/			
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Сургууль цэцэрлэг	3 сургууль, 3 цэцэрлэг (2016)	2,190	2,291	2,291	2,291	2,952	2,491	3,402	3,402
	3 сургууль, 1 цэцэрлэг (2017)		664	664	664		1,235	993	993
	3 сургууль, 3 цэцэрлэг (2018)			1,035	1,035			2,080	2,080
	5 цэцэрлэг (2019)				1,036				2139
	НИЙТ (9 сургууль, 12 цэцэрлэг)	2,190	2,955	3,990	5,026	2,952	3,726	6,475	8,614
Жишиг гудамж	61 өрх (2016)	5,517	5,595	5,595	5,595	12,160	14,601	20,792	20,792
	91 өрх (2017)		8,140	8,140	8,140		21,782	22,032	22,032
	60 өрх (2018)			5,623	5,623			6,645	6,645
	118 өрх (2019)				7,871				18,562
	НИЙТ (330 өрх)	5,517	13,735	19,358	27,229	12,160	36,383	49,469	68,031
Загвар өрх	6 өрх (2016)	548	546	546	546	1,166	2,167	1,583	1,583
	8 өрх (2017)		1,185	1,185	1,185		2,890	4,197	4,197
	8 өрх (2018)			948	948			1,880	1,880
	56 өрх, 1 ААН (2019)				5,237				24,925
	НИЙТ (78 өрх, 1 ААН)	548	1731	2679	7,916	1166	5057	7660	32585
НИЙТ	8,255	18,421	26,027	40,171	16,278	45,166	63,604	109,230	

Загвар өрх Хашаагаа үлгэр жишээ тохижуулан, өрхийн тариалан хөгжүүлэх, дүүрэг хорооны хүнсний ногоо тарих сонирхолтой иргэдэд мэдлэг туршлагаа хуваалцах, цаашид сургалт зөвлөгөө өгөх төв болох зорилготой загвар өрхүүд 2018 онд нийт 21 байгуулагдсан байсан бол 2019 онд 8 өрх шинээр орж нийт 29 болж нэмэгдлээ. Эдгээр өрхүүд хороо дүүргийнхээ ногоо тарих сонирхолтой иргэдэд зөвлөгөө өгч байна. Мөн Загвар өрхүүд үрсэлгээ бойжуулах, зах зээлд ногооны нийлүүлэлт бага болж, үнэ өндөр болох үед ногоо нийлүүлэх, борлуулах зорилготой дулаалгатай хүлэмж барьж ашиглаж эхэлсэн нь төслийн дэмжлэгийн үр дүн болж байна. Шинээр сонгогдсон 6 загвар өрх нийт 596м² хүнсний ногоо тариалсан бол 2019 онд нийт 29 загвар өрх нийт 3,824м² талбайд 13 нэр төрлийн ногоо тарьсан. Мөн 2019 онд 9 загвар өрх төсөлд хамрагдаагүй 45 өрхөд зөвөлгөө өгч тэдгээр өрхүүд нь нийт 1,683м² талбайд ногоо тарьж, 2,993 кг ургац хураан авсан мэдээтэй байна.

Үрслэг бойжуулах төв Сонгинохайрхан дүүргийн “Жишиг гудамж”-ны бүлгийн өрхүүд үрсэлгээний төвдөө чинжүү, лооль, хэмхийн үрсэлгээ, мөн салат, бууцай зэрэг бага тархацтай навчит ногоонуудыг үрээр тариалаад байна. Одоогийн байдлаар үрсэлгээ, богино болцтой ногоо зарж 1,5 сая төгрөгийн орлого олж, гудамжныхаа 11 өрхөд 7 төрлийн 427 ширхэг үрсэлгээг тараан өгчээ. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын туршлагатай ногоочин төслийн дэмжлэгээр үрсэлгээний төв байгууллаа. Үрсэлгээний төв ашиглалтанд орсоноор Мөрөн сумын болон хөдөө сумдаас сургалт, зөвөлгөө авах ногоочдод газар дээр нь үзүүлж харуулах боломж бүрдсэн. Энэ онд шинээр төсөлд хамрагдсан үр шим хүртэгчид, орон нутгийн ногоочдод чанартай үрсэлгээ бойжуулан нийлүүлсэн. **Орхон, Хөвсгөл аймгийн үрслэгийн төвүүд 7,150 ширхэг үрслэг ургуулж үүнээс 1,350 ширхэийг орлого багатай өрхүүдэд үнэгүй олгож, 2,000 ширхэг үрслэгийг 40% хямдралтай, 4,000 үрслэгийг зах зээлийн үнээр борлуулж нийт 7 сая төгрөгийн орлого олжээ.**

Үр дүн 3.2: Хот болон хот орчмын бүсэд хүнсний ногооны хэрэглээ нэмэгдсэн байна.

2019 онд 5 цэцэрлэг төслийн дэмжлэгт хамрагдаж одоогоор нийт 9 сургууль, 11 цэцэрлэг нийт 5,032м² ногоо тарьсан. Төсөлд хамрагдсан сургууль цэцэрлэгүүдийн багш, ажилчид болон 9 дүүргийн төрийн өмчийн 209 цэцэрлэгийн тогооч нарт “Хүүхдийн хоолыг хүнсний ногоогоор баяжуулж шим тэжээлийг нэмэгдүүлэн зохистой хооллох” сэдэвт сургалтыг 2019 оны 4 сард амжилттай явуулав. Мөн хоолны нэр төрөл, чанарыг өөрчлөхөөс гадна, эцэг эхэд нөлөөлөх, ногоо тарьдаг өрхүүдийн тоог нэмэгдүүлэх, хоол тэжээлийн чанарт өөрчлөлт оруулах зорилготой 10 удаагийн сургалт зохион байгуулж 356 хүн (95% эмэгтэй) хамрагдсан. Сургууль цэцэрлэгт хамрагддаг хүүхдүүдийн эцэг эх энэхүү сургалтанд сууж ногоо тарьж, хэрэглэж сурсанаар ногоо тарьдаг өрхүүдийн тоо нэмэгдэж, хүүхдүүдийн хоол тэжээлийн чанар, хүнсний ногооны хэрэглээ сайжирч, сургууль цэцэрлэг эцэг эхийн хоорондын харьцаанд илүү эерэг өөрчлөлт орж байгаа гэж үзэж болно. Зарим цэцэрлэгийн удирдлагууд “...Хүүхдийн хоол тэжээлийн чанарыг зөвхөн цэцэрлэгээс гадна гэртээ идэх хоол хүнснээс авах нь чухал байна. Тиймээс бид эцэг эхчүүдэд энэ төрлийн сургалтыг өгөх, мөн ногоо тарихыг эцэг эхчүүдэд зааж нөлөөлөх нь илүү үр дүнтэй болно...” хэмээн сургалтын нэмэлт захиалгыг төслөөс хүсч байлаа.

2019 онд ногоо тарьж байгаа багш ажилчдын дунд нөлөөллийн судалгаа явуулсан. Судалгааны дүнд нийт 29 сургууль цэцэрлэгийн 1,369 багш, ажилтаны 243 нь хашаандаа ногоо тарьж 28,519 кг ургац хураан авсан судалгаа гарсан. Энэ нь төслийн үйл ажиллагааны нөлөөллийн үр дүн гэж дүгнэж болно.

Үр дүн 3.3: Эмзэг бүлгийн өрхүүд сургалтанд хамрагдаж, мэдлэг мэдээллээр хангагдсан байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэг, хөдөө орон нутгийн 3 аймгийн төсөлд хамрагдаагүй ногоо тарих сонирхолтой, орлого багатай иргэдэд цогц мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 416 иргэн (73% эмэгтэй) эдгээрийн 10 өрх толгойлсон эмэгтэй (2,4%), хөгжлийн бэрхшээлтэй иргэд 20 (4,8%) хамрагдлаа. Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн газраас хүлэмжийн тариалан эрхлэдэг ногоочдод зориулсан сургалт явуулах хүсэлтийг төсөлд хүргүүлсэний дагуу “Атрын шим” компанитай хамтран цуврал сургалтуудыг зохион байгуулж байна. “Атрын шим” ХХК нь монголын хүлэмжийн аж ахуй эрхлэдэг томоохон аж ахуйнуудын нэг, өвөл, зуны хүлэмжинд олон төрлийн ногоо тариалдаг, сургалтын танхимтай, дадлагын талбайтай, туршлагатай мэргэжлийн багштай тул сургалт илүү үр дүнтэй болж байна.

Хүнсний ногооны худалдааны цэг 2017 онд зорилтот дүүргүүдийн үр шим хүртэгчдийн өрхийн хэрэгцээнээс илүү гарсан болон дотооддоо үйлдвэрлэсэн ногоо борлуулах зорилготой худалдааны цэгүүдийг Хан-Уул, Налайх дүүргүүдэд нээн ажиллуулж эхэлсэн. 2017-2019 онд нийт 4 борлуулах цэгийг тогтмол ажиллуулж байна. Үүний үр дүнд 23 өрх үндсэн дөрвөн нэр төрлийн ногоог борлуулж, жилд ойролцоогоор 9 сая төгрөгийн нэмэлт орлого олох боломжтой ажиллаж байна.

Хүнсний ногооны үрийн багц Төслийн зүгээс сайн чанартай хүнсний ногооны үрийн багц бэлтгэж, тарих зөвлөмжийн хамт хүнсний ногоо эхлэн тарьж буй иргэдэд тараан, зөвөлгөө өгч, хүнсний ногоо тарих сонирхолыг төрүүлэх, ногоо тарьдаг өрхүүдийн тоог нэмэгдүүлэх, стандартын чанартай ногооны үрийг тариулах зорилготой ажилласан. Жижиг хашаатай өрхүүдэд зориулж 35м² хэмжээтэй газарт тарих 13 төрлийн ногооны үрийн багцыг гарын авлагын хамт 2,000 ширхэгийг гаргаснаас 1,152 ногоо тарих сонирхолтой өрхөд олгосон.

Туршлага судлах аялал 2019 онд төсөлд хамрагдсан үр шим хүртэгчид хоорондоо харилцан туршлага судлах аялалыг зохион байгуулсан нь үр дүнтэй ажил боллоо. Улаанбаатар хотын үр шим хүртэгчдээс 9 хүн Дархан, Эрдэнэт, Хөвсгөл аймагт хүнсний ногооны ургалтын үеэр талбай дээр нь очиж заавар зөвөлгөө өгч, мөн хөдөө орон нутгийн хүмүүсийг Улаанбаатар хотод төсөл хэрэгжиж буй газруудын үйл ажиллагаатай танилцуулсан. Энэхүү үйл ажиллагаа нь хоорондоо танилцаж, бие биенээсээ суралцах, туршлагаа хуваалцах боломжуудыг гаргаж өгсөн.

Сургагч багш бэлтгэх сургалт “Ногоон Ази” ТББ-тай хамтран “Мод үржүүлэг, төмс хүнсний ногооны сургагч багш” бэлтгэх сургалтанд төсөлд хамрагдсан үр шим хүртэгчдээс 7 хүнийг хамруулан 6 удаагийн сургалтанд сургаж байна. Эдгээр сургагч багш нар цаашид төсөл хэрэгжиж буй зорилтот дүүргүүдийн тариаланчдад сургалт зөвлөгөө өгөх зорилготой юм. Сургалтанд оролцсон хүмүүс сургалт, зөвлөгөө өгөх мэргэжлийн гэрчилгээтэй төгсөж цаашид зөвлөх баг болж ажиллах юм. Бэлтгэгдсэн 9 сургагч багш нар 49 өрх, 1 аж ахуйн нэгжид сургалт зөвлөгөө өгсөнөөр 0.4 га талбайд тариалат хийж 13 тонн ургац хураан авчээ.

“Бүрэлдэхүүн хэсэг-3”-ын үр дүнгийн үзүүлэлтийн үнэлгээ

№	Үр дүнгийн үзүүлэлтүүд	2019 оны байдлаар		
		Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
1	Хүнсний ногоо тариалж буй өрхийн тоо	2400	2,133	88.1 %
2	Хүнсний ногоо тариалж, борлуулж, хэрэглэхэд үүсэх үнэ цэнэ, төгрөгөөр	>30% 160,000	224,000 40%	100.0 %
	Дундаж			94.1 %

Үр дүн 4.1: Хүнсний ногооны өртгийн сүлжээнд мөрдөгдөх ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээ, ургамал хамгааллын цогц арга хэмжээ, органик хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулсан байна.

“Таримал ургамлын үр, сортын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ хэлэлцэхээр шийдвэрлэлээ. төслийн дэмжлэгтэйгээр 2017 онд боловсруулсан Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдөр УИХ-д өргөн барилаа. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо (БОХХААБ)-ын хороогоор болон УИХ-ын нэгдсэн чуулганаар Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төслийг 2019 оны намрын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Улмаар уг хуулийн төслийг УИХ-ын чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг болон техникийн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг тус тус УИХ дээр байгуулсан. Мөн 2019 онд уг хуулийн төслийг олон улсын

зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх ажлыг төслийн зүгээс ажлын хэсэгтэй хамтран гүйцэтгэлээ. Түүнчлэн Таримал ургамлын шинэ сортын эрхийг хамгаалах /ТУШСЭХ/ ОУБ-ын зөвлөлийн 53-р хуралдаанаар уг хуулийн төслийг хэлэлцэж ТУШСЭХ олон улсын гэрээний зарчим, үзэл санаанд нийцсэн тул эерэг дүгнэлт гаргалаа. Энэ ОУБ-аас Дэлхийн үрийн нөхөрлөлтэй хамтран 2020 онд Монгол Улсад таримал ургамлын үр, сортын чиглэлээр арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна.

Журмын төслүүдийг боловсрууллаа Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн төслийг дагаж гарах дараах журмуудын төслийг төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэн боловсрууллаа. Үүнд:

- Шинэ сортын бүтээгчийн эрх авах өргөдлыг хянан шийдвэрлэх тухай;
- Таримал ургамлын шинэ сортыг ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох тухай;
- Таримал ургамлын шинэ сортыг нэрийг бүртгүүлэх тухай;
- Таримал ургамлын бүтээгчийн эрх олгох тухай;

Дээр дурдсан журмын төслүүдийг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн ба Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу тус яамны цахим сайтад байршуулан олон нийтийн санал авч байна.

Хууль батлагдсанаар хөдөө орон нутгийн тариаланчид баталгаажсан, нутагшсан, ган, халуун, өвчин, хортонд тэсвэртэй сортын үрээр өөрсдийн нутаг орны онцлогт тохируулан тариалалт хийх, таримал ургамлын үйлдвэрлэл, хүртээмж нэмэгдэх боломж бүрдэж байгаа юм. Мөн уг хуулиар сортын эрхийн хамгааллыг оюуны өмчөөр баталгаажуулан хамгаалах замаар шинэ сорт бүтээх үйл ажиллагааг дэмжинэ. Цаашлаад хүнсний аюулгүй байдлын индекс үндэсний хэмжээнд өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.

“Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” хэрэгжиж эхэллээ. Хүнсний тухай /2012/ хуулийн 7.2-т заасныг үндэслэн төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААЗД/-ыг хялбаршуулан заавар”-ыг ХХААХҮ-ийн сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019/05/29-ны өдрийн А/166, А/251 дугаар тушаалаар батлагдлаа. Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу уг ХААЗД-ын зааврыг 2019-06-18-ны 4406 дугаарт бүртгэснээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Жимс жимсгэнэ, хүнсний ногооны анхан шатны үйлдвэрлэлд “Хөдөө аж ахуйн зохистой дадал” нэвтрүүлснээр ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага хангагдах юм. **ХААЗД-ын заавар батлагдсан нь хэрэглэгчид эрүүл, аюулгүй, чанартай хүнсийг хэрэглэн эрүүл мэндээ дэмжих боломжийг нэмэн, улмаар нийгмийн эрүүл мэндийг дэмжин хамгаалахад чухал алхам боллоо.**

ХААЗД-ын зааврын хэрэгжилтийг зохион байгуулахад нэн шаардлагатай ХААЗД-ыг нэвтрүүлснийг баталгаажуулах үндэсний тогтолцоо бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд Эс Эф Си Эс ХХК-баталгаажуулалтын байгууллага болон 1-р бүрэлдэхүүн хэсэгтэй хамтарч ХААЗД-ыг нэвтрүүлэхэд туслах үүрэгтэй гол субъект болох зөвлөх /11/ болон баталгаажуулалт хийх аудитор /11/-ыг танхимын болон дадлагажих сургалтаар бэлтгэсэн. Сургалтаар бэлтгэсэн зөвлөхүүд ХААЗД-ыг өөрийн үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлэх талаар Атрын шим ХХК, Сэмжит Оюу ХХК-иудад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Үүний үр дүнд Дэвшил трейд ХХК, Атрын шим ХХК, Сэмжит Оюу ХХК-иудыг үйл ажиллагаандаа ХААЗД нэвтрүүлснийг Эс Эф Си Эс ХХК баталгаажуулан гэрчилгээ олголоо. Монгол Улсад анх удаа ХААЗД нэвтрүүлсэн хүлэмжийн аж ахуйд үйлдвэрлэгдсэн хүнсний ногоо зах зээл гарч хэрэглэгчийн ширээн дээр хүрч эхэллээ. 2019 оны Намрын ногоон өдрүүдийн үеэр Дэвшил ХХК-ийг уг үзэсгэлэн-худалдаанд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлж, эдгээр ногоочдын тарьж ургуулсан хүнсний ногоо болон ХААЗД-ын талаарх ойлголтыг хэрэглэгчдэд сурталчлах ажилд хувь нэмэр оруулав.

Органик хүнсний тухай хууль Органик хүнсний тухай хууль болон органик болохыг баталсан тэмдэг тэмдэглэгээг хэрэглэх журмын хэрэгжилтийн байдалд олон нийтийн хяналтыг төслийн зүгээс санхүүжүүлэн, ХХААХҮЯ-тай хамтран зохион байгууллаа. Уг хяналтыг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа Эфэс, Наран, Гүүд прайс, Сансар, Номин, Миний сүлжээ, М-март, И-март зэрэг томоохон 15 сүлжээ дэлгүүрийг хамруулан 2019 оны 9 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд ХХААХҮЯ, Монголын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо (МХЭАХНҮХ)-ны баталсан удирдамжийн дагуу ХХААХҮ-ийн салбарын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, “Монголын ХАА-н дэвшил холбоо”, “Тохирлын үнэлгээний байгууллагын хөгжлийн төв” төрийн бус байгууллагууд хамтран хийлээ. Энэ ажил нь хүнсний салбарт анх удаа олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн үйл явдал болсон. Тандан судалгаанд дээр дурдсан сүлжээ дэлгүүрээр зарагдаж байгаа дотоодын үйлдвэрийн органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээтэй 103 бүтээгдэхүүний болон импортын 214 бүтээгдэхүүний шошгоны мэдээллийг хамруулсан ба эдгээр бүтээгдэхүүний 39 нь амьтны гаралтай, 278 нь ургамлын гаралтай байсан байна. Эдгээр бүтээгдэхүүний ихэнх нь Органик хүнсний тухай /2016/ хуулиар эрх бүхий

байгууллагаар баталгаажуулаагүй, улсын бүртгэлд бүртгүүлэлгүй “байгалийн гаралтай цэвэр”, “байгалийн гаралтай”, “органик” гэсэн нэр томъёо бүхий шошготой зарагдаж байгаа нь илэрчээ. Энэ байдал нь органик хүнсийг хэрхэн худалдан борлуулах талаарх эрх зүйн орчны мэдлэг хүнсний худалдаа эрхлэгчдэд дутмаг байгааг харуулж байна, цаашид мэдлэг түгээх хэрэгцээ шаардлага их байна гэж дүгнэжээ.

Үр дүн 4.2: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ, органик хөдөө аж ахуйн талаарх бодлого, эрх зүйн орчны талаар төрийн албан хаагчдыг мэдлэгжүүлж, чадавхижуулсан байна.

ХХААХҮЯ, Монголын Бүтээмжийн Төв, “Глобал коммунитис” ОУБ-тай хамтран “Монгол Улсад ХААЗД-ыг хэвшүүлэх нь” сэдэвт 3 өдрийн сургалт-семинарыг 50 орчим оролцогчтойгоор (ХХААХҮЯ, МХЕГ, СХГ болон ногоочид) зохион байгуулав. Уг сургалтаар ХААЗД-ын талаарх мэдлэг олгож, түүнийг нэвтрүүлж байгаа бусад орны туршлагаас хуваалцлаа.

ХХААХҮЯ-тай хамтран “Ургамал хамгаалал, хөрсний үржил шимийн менежмент” сэдэвт сургалтыг төв, зүүн бүсийн аймаг, сумдын ХАА-н мэргэжилтнүүд, ургамал хамгаалал, хорио цээрийн байцаагчид, ногоочдод нийт 100 орчим хүнд амжилттай зохион байгууллаа. Эдгээр 2 сургалтаар ургамал хамгааллын салбарын эрх зүйн орчин, бодлогын талаар оролцогчдод дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Мөн хүнсний ногооны ургамал хамгаалал, голлох хөнөөлт организмыг таних, тодорхойлох, тэмцэх арга, ургамал хамгааллын цогц арга (УХЦА), хөрс хамгаалах, түүний үржил шимийг сайжруулах, хөрсний эдийн засгийн үнэлгээ, органик болон компост бордоо бэлтгэх, тун норм тодорхойлох, хэрэглэх талаарх оролцогчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлсэн.

Монголын Бүтээмжийн төв болон “Глобал Коммунитис” ОУБ-тай хамтран “Хүнсний сүлжээний туршид аюулгүй байдал, чанарыг тогтвортой хангах нь” сэдэвт чадавхийг бэхжүүлэх Үндэсний семинарийг зохион байгууллаа. Сургалтанд Улаанбаатар хот орчмын хүлэмжийн аж ахуй эрхлэгчид болон холбогдох төрийн байгууллагуудын албан хаагчид нийлсэн 40 гаруй хүн хамрагдсан. Хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлын асуудал, хүнсний сүлжээний туршид аюулгүй байдал, чанарыг тогтвортой хангах тогтолцоог бүрдүүлэхэд дижитал технологийг нэвтрүүлэх боломж (ИОТ), Блокчэйн, Том дататай хиймэл оюун ухааныг хөгжүүлэх зэрэг сэдвүүдийг хөндсөн илтгэл тавигдсан. Семинарын үр дүнд оролцогчид өрсөлдөх чадвараа сайжруулах, аж ахуйгаа тогтвортой эрхлэх, хэрэглэгчийн хэрэгцээ-шаардлагад нийцсэн эрсдэл багатай, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мэдээллийн технологийн ололтыг ашиглах талаарх шинэ мэдлэг, мэдээлэл олж авлаа.

“ХААЗД-ыг нэвтрүүлэх, хяналт тавих нь” сэдэвт сургалтыг ногоочдын төлөөлөл болон Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ)-ын Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт байцаагч нарыг (10 аймгаас) оролцуулан зохион байгууллаа. Сургалтын гол зорилго нь ХААЗД-ыг нэвтрүүлэхэд дотоод аудиторууд юуг анхаарах ёстой, хэрхэн ажиллах ёстойг таниулах байлаа. Уг сургалтын онцлог нь үйлдвэрлэгчид улсын байцаагчидтай хамт технологийн сургалтанд хамрагдаж, асууж тодруулах зүйл болон үүсэх хүндрэл бэрхшээлийг ярилцан хэлэлцсэн сургалт болсон. Сургалтын үеэр хэлэлцсэн нэг асуудал нь МХЕГ болон баталгаажуулалтын байгууллага хоёрын хоорондын харилцан хамаарлын асуудал байсан. Хэрэв хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага ХААЗД-ыг нэвтрүүлсэн гэж баталгаажуулалт хийчихсэн байхад МХГ-аас ХААЗД-ын хэрэгжүүлэлт хангалтгүй гэж үзвэл тухайн аж ахуйн нэгж ямар арга хэмжээ авах гэсэн гэдэг асуудал дээр талууд хэлэлцэж нэгдсэн ойлголтод хүрлээ.

“Ургамал хамгааллын цогц арга” сургагч багшийн сургалтыг ХХААХҮЯ, Монголын бүтээмжийн төвтэй хамтран 12 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Азийн Бүтээмжийн төвийн зөвлөх Доктор, Проф., Сринивасан Рамасами, БНСУ-ын КОПИА Монгол төвийн захирал Чой Ман Ён нарыг оролцуулан амжилттай зохион байгууллаа. Уг 2 өдрийн сургалтанд ургамал хамгааллын чиглэлийн багш, мэргэжилтэн, судлаач, шинжээчид түлхүү оролцсон. Сургалтаар гол хөнөөлт хортон, шавьж, тэдгээрийн харилцан хамаарал зэрэг ойлголтоос гадна УХЦА-ыг Азийн орнуудад хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх сайн туршлагаас хуваалцлаа. 50 орчим оролцогч хамрагдсан уг сургалтын төгсгөлд сургалтаар олж авсан мэдлэгээ баталгаажуулан байцаа, сонгино, өргөст хэмх, улаан лооль болон чацарганы тариалалтад УХЦА-ыг хэрэгжүүлэх шаталсан 7 аргын дагуу тухайн таримлын үйлдвэрлэлд хэрэглэх загварыг багаар ажиллан гаргалаа. Оролцогчид УХЦА-ын сургагч багшийн гэрчилгээг гардан авлаа.

Үр дүн 4.3: Ургамал хамгааллын цогц арга хэмжээ, пестицид, органик үйлдвэрлэл зэрэгтэй холбогдсон эрх зүйн орчинг хэрэгжүүлэх ажлыг сумын түвшинд турших, тэдгээрийн үр дүнг баримтжуулах

Орон нутагт сургалт зохион байгууллаа. УХЦА ХААЗД, органик үйлдвэрлэлийн асуудлыг хамарсан холбогдох хууль тогтоомж, журам, заавар, бодлогын талаар суурь ойлголтгүй бол тариаланчдад талбайн түүхийн дэвтэр хөтлөх, ул мөрийг мөшгих бүртгэл хөтлөхөд хүндрэл бэрхшээл учирдаг.

Энэ шалтгааны улмаас ногоочид талбайн түүхийн дэвтрийг хөтлөх дургүй, ашиглах хандлага нь бага байсаар байна. Ногооны гарал үүслийн гэрчилгээ нь талбайн түүхийн дэвтэрийн хөтлөлт дээр үндэслэн олгогддог. Тиймээс талбайн түүхийн дэвтэр хөтлөхгүй бол тухайн тариаланч гарал үүслийн гэрчилгээ авах эрх нь үүсэхгүй. Энэ шаардлагын үүднээс төслийн зүгээс зорилтот 4 сум болох Сэлэнгэ аймгийн Мандал сум, Дархан-Уул аймгийн Орхон сум, Орхон аймгийн Жаргалант сум, Төв аймгийн Борнуур сумдын ногоочдод зориулсан сургалт зохион байгууллаа. Сургалтын үр дүнд ногоочдын мэдлэг дундажаар 28.2 хувиар ахисан үзүүлэлттэй байна. Сургалтанд хамрагдсан нийт ногоочдын 86% нь сургалт зохион байгуулсанд талархал илэрхийллээ.

Органик хүнсийг баталгаажуулах туршилтын төсөд 2019 оны 5 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд тариаланч болон сумдын ХАА-н мэргэжилтэн, байцаагчийг оролцуулан нийт 24 хүнд органик үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, техникийн шаардлага, органик хүнсний ногооны ургамал хамгаалах цогц технологи, баталгаажуулалт, оролцооны баталгаажуулалт, хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулах тухай сургалтыг зохион байгууллаа. 2015 онд батлагдсан “Органик хүнсний тухай хууль”-нд заасан баталгаажуулалт хийх арга хэлбэрийн нэгийг хэрэгжүүлэх хамтын баталгаажуулалтын байгууллага (ХББ) 2019 оныг хүртэл нэг ч байгуулагдаагүй байсан бол уг сургалтын үр дүнгээр төслийн дэмжлэгтэйгээр Органик хөгжил ХББ болон Борнуур Органик Хүнс ХББ байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүллээ. Үүний үр дүнд Органик хүнсний тухай /2015/ хуульд заасны дагуу органик үйлдвэрлэлийг баталгаажуулах аргын нэг болох харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад талууд хамтран баталгаажуулах ажлыг эхлүүлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын анхны ХББ болох “Органик хөгжил”, түүний дараа Борнуур органик хүнс ХББ тус тус байгуулагдав. Эдгээр 2 ХББ-г байгуулахад төслийн зүгээс арга зүйн зөвлөмжөөр хангаж, техникийн туслалцаа үзүүлж ажиллалаа. Тухайлбал, төслийн зүгээс тус ХББ-г байгуулсныг ХХААХҮЯ бүртгэж авах гол шаардлага болох уг ХББ-ын гишүүд оролцооны баталгаажуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх хамтран ажиллах гэрээний загварыг боловсруулж зөвлөх үйлчилгээ үзүүллээ. Үүний үр дүнд ХХААХҮЯ уг ХББ-г бүртгэснийг баталгаажуулж бүртгэлийн хуудас олгов. Төслийн зүгээс оролцооны баталгаажуулалтыг гүйцэтгэх аудитуудыг бэлтгэхэд техникийн туслалцаа үзүүлэн сургалтыг зохион байгуулсан. Эдгээр ХББ-г байгуулж, ХХААҮЯ бүртгэснээр улсын хэмжээнд органик хүнсний оролцооны баталгаажуулалтын тогтолцоо бүрдүүлэх анхны алхам хийгдлээ.

Монгол Улсад хүнсний ногоог органик болохыг баталгаажуулж эхэллээ. Төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Монгол Улсын анхны ХББ болох Органик хөгжил ХББ нь өөрийн гишүүн Гэр гарден органик ХХК-ийн тарьж ургуулсан нийт 13 төрлийн хүнсний ногоог органик аргаар үйлдвэрлэснийг баталгаажуулан ХХААХҮЯ-ны www.organic.gov.mn сайт дахь органик хүнсний улсын бүртгэлд бүртгүүлэн органик шошготойгоор зах зээлд нийлүүлж байна. Төслийн зүгээс 2019 оны Намрын ногоон өдрүүдийн үеэр Органик хөгжил ХББ, Борнуур органик хүнс ХББ-ыг уг үзэсгэлэн-худалдаанд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлж, эдгээр ногоочдын тарьж ургуулсан органик хүнсний ногоог хэрэглэгчдэд сурталчлах ажилд хувь нэмэр оруулав.

“Алсыг харъя, органикийг сонгоё” аян “Алсыг харъя, органикийг сонгоё” нэрийн дор зохион байгуулагдсан 1 сарын ажлыг ХХААХҮЯ, МХЕГ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулж идэвхтэй оролцлоо. Ажлын нээлт, хаалтын үеэр хийгдсэн хэвлэлийн бага хуралд Органик хөгжил ХББ-гийн төлөөлөл оролцож органик үйлдвэрлэл эрхлэх боломж, ашиг тус, оролцооны баталгаажуулалтын давуу талын талаар нийтэд мэдээлэл хийлээ. Уг ажлыг зохион байгуулснаар органик хүнсний тухай эрх зүйн орчны талаарх үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгч, хэрэглэгчийн мэдлэг мэдээлэл нэмэгдлээ. Хугацаа богино ч органик үйлдвэрлэлийн зарчим, хэв маяг, ердийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээс ялгагдах онцлог, түүнийг баталгаажуулах, бүртгэх, худалдах, хуурамч хаяг шошго хэрэглэхээс татгалзах, шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа эрхлэх үүрэгтэйг ойлгуулсан үр дүнтэй ажил болж өндөрлөлөө.

“Органик үйлдвэрлэгчдийн IY чуулган” боллоо. ХХААХҮЯ-тай хамтран Органик хүнс хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн талаар оролцогчдын дуу хоолойг сонсох, тулгамдаад байгаа асуудлыг хэлэлцэх, арга замыг тодорхойлох зорилго бүхий “Органик үйлдвэрлэгчдийн IY чуулган”-ыг 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулав. Уг арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, хүнсний ногоочид, үйлдвэрлэгчдийн 160 хүний төлөөлөл оролцлоо. Уг форумар органик хөдөө аж ахуйг хамтын зарчмаар баталгаажуулахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг хэлэлцэж, цаашид энэ чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг ярилцлаа.

“Органик бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээ” сэдэвт сургалт амжилттай зохион байгууллаа. 2019 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд “Органик бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээ” сэдэвт 3 өдрийн сургалтыг ХХААХҮЯ болон Адра ОУБ-тай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад “Органик хөгжил”, “Борнуур органик”, “Сэлэнгэ Органик” хамтын баталгаажуулалтын

байгууллага, “Эс эф си эс” ХХК-хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагын төлөөллөөс гадна хүнсний ногоочид, үйлдвэрлэгчид нийлээд 100 орчим оролцогч хамрагдсан. Азийн бүтээмжийн байгууллагын зөвлөх хатагтай Камал Мелвани органик хүнсний үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, байгаль орчинд орчинд ээлтэй, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх улмаар зах зээлд гарах, бренд бүтээгдэхүүнийг бий болгох, хэрэглэгчдийн итгэл үнэмшлийг олж авах, үйлдвэрлэгчдийн борлуулалт, ашиг орлого нэмэгдэхэд хөндлөнгийн болон хамтын баталгаажуулалтын гүйцэтгэх үүргийн талаарх мэдлэгийг уг сургалтанд оролцогчдод хүргэж, олон улсын сайн туршлагаас хуваалцлаа. Органик хөдөө аж ахуйг эрхлэх нь хариуцлагатай, ёс зүйтэй үйл ажиллагаа бөгөөд уйгагүй хөдөлмөр, хичээл зүтгэлийн дүнд бий болдог гэсэн итгэл үнэмшлийг нь сургалтанд оролцогчдод улам бататгаж өглөө.

“ХААЗД-ыг нэвтрүүлэх нь” сургалтыг амжилттай зохион байгууллаа. “Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” батлагдсаны дараагаар уг зааврыг таниулах, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх технологийн зөвлөгөө өгөх зорилготойгоор 113 оролцогч бүхий үндэсний хэмжээний сургалтыг 2019.12.07-ны өдөр зохион байгууллаа. Монгол Улсад анх удаа ХААЗД-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар батлагдсаны дараа түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх дэлгэрэнгүй ойлголтыг өгснөөрөө онцлог сургалт байлаа. ХХААХҮЯ-ны төлөөлөл, МХЕГ-ын нийслэл болон аймгуудын байцаагч нар, мэргэжлийн холбоод, судлаач, шинжээчид, ногоочид, үйлдвэрлэгчид гэсэн бүх талын төлөөлөл оролцсон ба уг сургалтыг оролцогчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй сургалт боллоо гэж дүгнэсэн байна. Сургалтын өмнөх болон дараах 2 удаагийн мэдлэг шалгах 3 асуулт бүхий үнэлгээгээр оролцогчдын мэдлэг сургалтын дараа 20 хувиар нэмэгдсэн байлаа.

Хүнсний ногооны салбарт ажиллагсдын бодлого эрх зүйн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь эмхэтгэлүүдийг нэгтгэн хэвлүүлж олны хүртээл болгов. Монгол Улсын УИХ-аас баталсан хууль тогтоомж, Засгийн газраас болон ХХААХҮ-ийн сайдын дангаар болон холбогдох бусад сайдтай хамтран баталсан Тариалангийн салбарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрх зүйн орчны эмхэтгэлийг нэгтгэн 500 хувийг хэвлүүлэн сургалтын үеэр оролцогчдод тараав.

Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд ХААЗД-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар батлагдсантай холбогдуулан энэ талаарх эрх зүйн орчны эмхэтгэлийг 500 хувийг хэвлүүлэн сургалтын үеэр оролцогчдод тараав.

Тариалангийн салбарт мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгийг эмхэтгэж салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид, ногоочдын хүртэл болгосоноор тэдний хууль, эрх зүйн талаарх мэдлэг нэмэгдэн, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад дөхөмтэй болно.

Бүрэлдэхүүн хэсэг-4 Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Үр дүнгийн үзүүлэлтүүд	Суурь	Төлөвлөсөн	Биелэлт	Хувь
Хүнсний ногооны салбарын ургамал хамгааллын цогц аргын үйл ажиллагааны хөтөлбөр	0	1	70	70 %
Органик хөдөө аж ахуйг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах	0	1	100	100 %
Ургамал хамгааллын бодисын эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох, УХБ-ын үлдэгдэл, хяналт	0	1	70	70 %
Бүрэлдэхүүн хэсэг 4-ХШҮ				80%

2. ЖЕНДЭР

Төсөл үйл ажиллагаандаа жендерийн асуудлыг чухлаар авч үзсээр байдаг. Аливаа үйл ажиллагаанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаардаг бөгөөд төлөвлөлт, хяналт, хэрэгжүүлэлт, шийдвэр гаргах, тэргүүн туршлага нэвтрүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагаандаа эмэгтэй оролцогчид, фермерүүдийг тэнцвэртэй байдлаар оролцуулахад анхааран ажиллаж байна. Сургалтанд оролцогчдын 60-70% нь эмэгтэй тариаланчид байдаг бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн идэвх оролцоо тус салбарт их байдгийн жишээ юм. Мөн хоршооны удирдлагад эмэгтэй тэргүүлэгч нар голлож байгаа нь цаашид эмэгтэйчүүдийн манлайлал, нийгмийн идэвхийг нэмэгдүүлэхэд боломж нээлттэй байна.

2018 оны салбарын жендерийн бодлогод заасан дараах арга хэмжээг удирдлага болгон төслийн ажилтнууд болон ногоо тариалагчдын аль алиныг нь хамруулсан үйл ажиллагаа зохион байгууллаа. Мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын жендерийн тэгш байдлыг хангахын тулд үр дүнтэй, уялдаа холбоо бүхий доноруудын хамтын ажиллагааг дээшлүүлэх талаар тус бодлогод тодорхойлсон (3.4-т) байдаг. Тухайлбал, “Газар тариалангийн зохистой

үйлдвэрлэлийн чиглэлээрх сургалт, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх төслүүдийн эмэгтэйчүүдийг хүнсний ногоо дахин боловсруулах, бичил бизнесийг хөгжүүлэх, бүлэг **хоршоогоор ажиллахад дэмжлэг үзүүлэх чиглэлийг жендэрийн бодлогын хэрэгжилттэй уялдуулах**” гэсэн.

Бодлогын энэхүү хүрээтэй уялдуулан төслийн ажилтнууд, хоршоодын гишүүдэд зориулсан дөрвөн удаагийн сургалтыг зөвлөхийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан болно. Мөн жендэрийн мэдрэмжтэй сайн туршлага бий болгох фэйсбүүк/сошиал медиа кампанит ажлыг ногоо тариалагч хоршоодын дунд зохион байгуулсан.

Ногоо тариалагч хоршоодын гишүүдэд зориулсан дөрвөн удаагийн сургалтыг зохион байгуулж Борнуур, Зүүнхараа, Орхон сумын ногоочдын 3 бүлэг, 5 хоршоо хамрагдлаа. Сургалтанд оролцогчдын санал дүгнэлтээс үзвэл ногоочид өөр дээрээ эргэцүүлж, өөрчлөлт хийх хүсэл сонирхолтой байгаа нь сайшаалтай байлаа. Гүнзгийрүүлсэн хэлэлцүүлгийг тогтмол өрнүүлэх, аюулгүй орчныг бий болгох нь хоршооны гишүүд жендэрийнхээ асуудалд ач холбогдол өгч, бүтээлчээр хандах боломжтой болгодог. Тухайлбал, Дархан-Уул сумын хоршооны гишүүн эрэгтэй дараах саналыг гаргасан: *“Жендэрт анхаарах нь хүн бүрт тустай болгохыг ойлгож авлаа. Миний хувьд хоршооныхоо дүрэмд өөрчлөлт оруулах санаа төрлөө. Жишээлбэл, хоршооны тэргүүний албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүнийг ээлжлэн сонгоно. Эсвэл нь эрэгтэй хүн бол, орлогч нь заавал эмэгтэй хүн байна гэж зааж болох юм байна.”*

Жендэрийн мэдрэмжтэй хоршоодын сайн туршлагыг бий болгохоор энэхүү фэйсбүүк аяныг санаачилсан. Энэхүү фэйсбүүк аяныг салбарын жендэрийн бодлогод заасан зөвлөмж (2, 4, 6 дугаар)-ид тулгуурлан зорилго, агуулгыг тодорхойлсон. Фэйсбүүк бол Монголын хамгийн түгээмэл сошиал медиа бөгөөд бүх сошиал медиа хэрэглээний 85% хувьд фэйсбүүкийн аппликейшн байдаг. Статистик мэдээгээр 1,9 сая фэйсбүүк хэрэглэгч Монголд байна. Ногоочдын хувьд Фэйсбүүкийг хэрэглэх нь зах зээлтэй холбогдох, бизнесийн түншийг хайж олох, хоршоодоор дамжуулан хамтын ажиллагааг сурталчлах зэрэг бусад сошиал медиа сувгуудаас илүү өргөн боломжтой юм. Санхүүгийн дарамтаас гарах шийдэл нь бүтээлч маркетинг, брэнд бий болгоно. Фэйсбүүк аянд 5 хоршоо, 3 ногоо тариалагчдын бүлэг оролцсон бөгөөд аянд оролцсон хоршоод бизнес чиглэлээр фэйсбүүк ашиглаж байсан туршлагагүй байлаа. Энэхүү аян нь ногоо тариалагчдад фэйсбүүк хуудсыг амжилттай хөтлөн явуулах (нийтлэл бичих, видео бүтээх, хоршооны танилцуулгыг оруулах гэх мэт) ур чадварт суралцлаа.

3. ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН УЯЛДАА ХОЛБОО

Төсөл ХХААХҮЯ болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгжүүдэд, тухайлбал Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй "Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амжиргааг сайжруулах" төсөл, АДРА ОУБ-ын "Органик ХАА-н түншлэл" төсөл, НҮБ-ын ХХААБ-ын "Secim Нэмүү өртгийн сүлжээ" төсөл гэх мэт, чанартай, гарал үүсэл нь тодорхой хүнсний ногооны үрийг нийлүүлж, түгээж ажиллаж байна.

Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай нягт хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Мөн баталгаажуулалтын чиглэлээр мэргэшсэн байгууллагуудтай нээлттэй хамтран ажиллаж байна. Тухайлбал Монгол Улсад анх удаа ХААЗД-ыг нэвтрүүлэхээр Төв аймгийн нутаг дэвсгэрт Хүлэмжийн аж ахуй эрхэлдэг Атрын шим ХХК, Эс Эф Си Эс ХХК баталгаажуулалтын байгууллагатай баталгаажуулалтын гэрээ байгуулан ажиллаж байна.

4. СУРГАМЖ, ОЛОЛТ АМЖИЛТУУД

Тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд үнийн шударга өрсөлдөөнд нийлүүлдэг болоход анхан болон дунд шатны борлуулалтын хоршоо ихээхэн үүрэгтэй болохыг төслийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа "Цэвэр хөрсний шим" дундын хоршооны үр дүнгээс харагдаж байна. Тус хоршоо нь нэг жилийн хугацаанд гишүүн ногоочдынхоо нийт 460 сая төгрөгийн үнэ бүхий 363 тонн ногоог Номин супермаркет болон бусад гэрээт байгууллагуудад нийлүүлээд байна. Үүний үр дүнд ногоочид бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр шууд нийлүүлж харин хэрэглэгчид гарал үүсэл нь тодорхой эх орны хөрсөнд ургуулсан ногоогоо итгэл дүүрэн хэрэглэх боломж бүрдэж байна.

Төслийн жишиг гудамж аргачилал үр дүнтэй өгөөжтэй загвар болж байгаа нь орон нутгууд болон нийслэлийн дүүрэг хороод өөрсдийн санхүүжилтээр загварыг хэрэгжүүлэх төслөөс мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах хүсэлтээ ирүүлж байгаагаас харж болно. Төсөл орлого багатай иргэдэд хашаандаа ногоо тариалах, хэрэглэж заншихад дэмжлэг үзүүлсэнээр цаашид өрх орлогоо нэмэгдүүлэх санаачлага гаргахад сайнаар нөлөөлж байна.

5. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Төслийн мэдээллийн санг тогтмол баяжуулж, мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн ажиллаж байна. Төслийн хяналт үнэлгээний тоон мэдээллүүдийг төслийн бүртгэл, зорилтот

судалгаа, асуумж, орон нутгийн статистикийн газар, хөдөө аж ахуйн газар, нийслэл, дүүргүүдийн хөдөө аж ахуйн газар, ХХААХҮЯ-ны албан ёсны тоон мэдээнд үндэслэн боловсруулж байна. Орон нутгаас шаардлагатай тоон мэдээллүүдийг шуурхай, бодитой авахын тулд орон нутгийн агрономчидтой мэдээлэл солилцох, хамтран ажиллаж байна.

Төслийн үр дүнд үнэлгээ хийх ээлжит судалгааг 2019 оны 4 сард хийлээ. “Энэхүү судалгаанаас гарсан гол дүгнэлт нь ногоо тарьдаг иргэдийн орлого эрс нэмэгдсэн байдал юм. Үндэсний статистикийн судалгаагаар хөдөөгийн өрхийн сарын орлого сүүлийн 3 жилийн туршид 11.49 % өссөн байхад төслийн хамрах нутгийн ногоочин өрхийн сарын орлого 2015 оны суурь үнэлгээтэй харьцуулахад 83.2% иар өссөн байдалтай байна. Судалгаанд оролцсон өрхийн 86%-ийн өрхийн орлого ногооны борлуулалтаас бүрдэж байна. Энэ нь 2015 оны тоотой харьцуулахад харьцангуй их байгаа юм. 2015 оны суурь судалгаагаар энэ тоо 54%, 2017 онд 53% тус тус байсан юм. Төслийн бүс нутагт нийт 20 гаруй шинэ сортын ногоо туршиж, тариалж эрхэлсэн нь ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн байх магадлалтай.”

6. САНХҮҮ, МЕНЕЖМЕНТ

2019 онд төслийн үйл ажиллагаанд (бүрэлдэхүүн хэсэг 1-3) 2,3 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 12-р сарын 31-ны байдлаар 89.4%-тай зарцуулалттай гүйцэтгэсэн.

Засгийн газар болон орон нутгийн оролцоо: 2019 оны 6 сарын байдлаар 176.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байгууллагуудаас худалдан авч 16.1 сая төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлээ. Мөн импортоор 283.1 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны эрлийз үр /байцаа, өргөст хэмх, улаан лооль, лууван/ худалдан авч гааль болон НӨАТ-аас 43.9 сая төгрөгийг чөлөөлүүлээ. (оны эцэсийн дүн нэгтгэгдээгүй байгаа болно)

Төслийн 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 115 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 46% ийг орон нутгаас, 19% ийг үр шим хүртэгчид өөрсдөө гаргасан байна. Төв аймгийн Атарын шим компаний дэргэд байгуулсан хүлэмжийн нэвтрүүлэх төвтэй 2019 онд байгуулсан гэрээний дагуу нийт 9 аймгийн 33 ногоочдыг хүлэмжийн дадлагажих вакумжуулсан сургалтанд хамрууллаа. Ногоочдын идэвх, хариуцлагыг сайжирч орон нутгаас ирэх, буцах замын зардалаа оролцогчид өөрсдөө харин байрны зардлын хагас төлбөрийг "Атарын шим" компани гаргасан байна.

Төсөл 2014-2018 онуудад сонгины тариалалтыг нэмэгдүүлэх зорилготой төл сонгиныг импортоор оруулж ирж тариаланчдад нийлүүлж байсан. Гэвч 2019 онд төсөв батлагдах хугацаа оройтсонтой холбоотойгоор худалдан авалт оройтож төсөвлөгдсөн 67,5 сая төгрөг зарцуулагдаагүй бөгөөд тус төсвийг сонгино хураагч техник авахад зарцуулсан болно.

ШХА-аас Монгол ногоо төслийн үр дүнд үндэслэн үйл ажиллагааны цаашдын тогтвортой байдлыг хангах, бэхжүүлэх зорилготой төслийн төгсгөлийн үе шат (2020-2022)-ыг хэрэгжүүлэх шийдвэр гаргалаа. Төслийн баримт бичиг боловсруулагдаж 2020 оны 2-р хагасаас төслийн төгсгөлийн үе шат хэрэгжиж эхлэхээр боллоо.

Хүснэгт 9: Зардлын товчоон 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар

#	Бүрэлдэхүүн хэсэг	Нийт төсөв ₮	2019 оны 12 сарын 31-ны байдлаар	
			мян.төг	хувиар
1	Хүнсний ногооны үйлдвэрлэл	774,562,194	692,942,535.30	89%
2	Маркетинг	393,400,000	369,600,485.56	94%
3	Гэр хорооллын тариалан	459,913,624	384,385,173.20	84%
4	Удирдлага	659,135,303	598,491,852.38	91%
	Нийт	2,287,011,121	2,045,420,046.44	89%
	Эрх зүйн орчин (ДХХАБ)	175,690 \$	149,542 \$	85%

Хүснэгт 10: Төсвийн зарцуулалт төрлөөр (сая төгрөгөөр) 2019.12.31

	Барилга, байгууламж	Зөвлөх үйлчилгээ	Тоног төхөөрөмж, эд хогшил	Бараа материал	Үйл ажиллагааны зардал	Сургалт	Дүн
Хүнсний ногооны үйлдвэрлэл	1	34	68	352	172	66	693
Маркетинг	115	22	-	92	110	31	370
Гэр хорооллын тариалан	24		25	71	222	43	385
Удирдлага	-	36	0,3	-	536	26	598
Дүн	140	92	93,3	515	1,040	166	2,046

Хавсралт 1: Сургалт, туршлага судлах аялалууд

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хүнсний ногооны үйлдвэрлэл

№	Сургалтын нэр	Хугацаа, байршил	Оролцогсад (% эмэгтэй)	Сургалтын үр дүн
1	Хүлэмжний дадлагажих сургалт	Төв аймаг Зуунмод хот “Атрын шим” хүлэмжийн аж ахуй 14 аймгийн 22 сумын тариаланчид	47 (77 % эм)	Хүлэмж, ил талбайн төрөл бүрийн ногоо ургуулах, үрслэг бэлтгэх, арчилгааны үеийн дадлагажих сургалтыг тариаланчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжлийн өндөр түвшинд, орчин үеийн арга техникийг танилцуулж, гардан гүйцэтгэхэд оролцуулах замаар дадлагажих сургалт нь тариаланчдын хувьд ихэд хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт болов. Ургалтын хугацаанд нийт 6 удаа, тус бүр 4 хоног.
2	ХААЗД-ын аудиторын сургалт	SFCS XXK-тай хамтран 4-р сарын 11-12	14 (86 % эм)	Баталгаажуулалтын үнэлгээг ISO17021, ISO17065, ISO17067 стандартын дагуу хийх чадамжтай болгохын тулд эдгээр баримт бичгүүд нь баталгаажуулалтын үнэлгээ хийх аудиторт шаардагдах мэдлэг, мэдээлэл өгөв. Бие даалт, танхимын сургалт, шалгалт өгөх хэлбэрээр явагдав.
3	ХААЗД-ын зөвлөхийн сургалт	SFCS XXK-тай хамтран 4-р сарын 8-9	14 (93 % эм)	ХААЗД-ыг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, баталгаажуулалт хийлгэхэд бэлтгэх, сургах, зөвлөгөө өгөх арга зүйг эзэмшүүлэх сургалт SFCS XXK-иас хамтран явуулав. Бие даалт, танхимын сургалт, дадлагын ажил, интерактив ярилцлагын хэлбэрээр явагдав. Нандинцэг зөвлөхөөр ажиллаж эхний 21 ААН-ийг ХААЗД-ын баталгаажуулалтыг амжиттай хэрэгжүүлэв.
4	“ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний хөгжил” сургалт, туршлага судла аялал	Төв аймаг Зуунмод хот, Борнуур сум, Дархан-Уул аймаг Орхон сум, 8-р сарын 12-14	33 (57 % эм)	Монгол, Японы экстейншиний тогтолцоо, экстейншиний хөгжлийн түүх, үйл ажиллагааны ялгаа, экстейншиний бодит үйл ажиллагааны арга барил, уялдаа, үүрэг роль, Экстейншиний хөгжилд төр, иргэн, аж ахуйн нэгж, бүс нутгийн оролцоо, байр суурь чиг хандлага, Экстейншиний ажилтнуудын мэдлэг, чадварыг хэрхэн дээшлүүлж, харилцагчтай хэрхэн холбож уялдуулдаг, үйл ажиллагааг хэрхэн идэвхжүүлж дэмжлэг үзүүлдэг талаар зааж, хэлэлцүүлэг хийгдэн, туршлага судлах аялалын хүрээнд экстейншины үйлчилгээ үзүүлж буй 4 газраар орж танилцлаа.
5	“Хүнсний ногооны үр үржүүлэг” сургалт	Увс, Улаангом 8-р сарын 20	34 (29 % эм)	Үндэс үртэн, төл сонгино, үрийн саримс, навчит үнэрт ногооны үржүүлэг, байцааны эрлийз үр үйлдвэрлэх технологийн танилцуулга зэрэг хийгдэв.
6	Хүлэмжний туршлага судлах аялал	БНХАУ, Хөх хот	2 (100 % эр)	БНХАУ-ын хүлэмжийн аж ахуйн шинэ, болон уламжлалт техник технологитой танилцах, тариаланчдын борлуулалтын сүлжээ, зохицуулалт зэрэгтэй танилцав.
7	“Хүнсний ногооны салбарын хөгжил, хэтийн төлөв” онол үйлдвэрлэлийн бага хурал	агрономчид, эрдэмтэн, судлаачид, 10 аймгийн хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчид	121 (67 % эм)	Хүнсний ногооны салбарын түүхэн хөгжил, өнөөгийн үйлдвэрлэлийн түвшин, цаашид дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэв. УГТХ, УХЭШХ болон ХААИС-ийн хүнсний ногооны чиглэлээр 2015 оноос хойш хийсэн судалгааны ажлынхаа үр дүнг мөн нийтэд танилцуулсан.
	НИЙТ	57 өдөр	265 (58 % эм)	

Бүрэлдэхүүн хэсэг 2: Хүнсний ногооны маркетинг

№	Сургалтын нэр	Хугацаа, байршил	Оролцогсад (% эмэгтэй)	Сургалтын үр дүн
1	Хоршооны тэргүүлэгчид болон бүх гишүүдийн хурал, семинар, сургалт, хэлэлцүүлэг	1 өдөр, Улаанбаатар хот	20 (55% эм)	Монгол ногоо төслийн зүгээс дундын хоршоотой цаашид хэрхэн хамтран ажиллах талаарх илтгэлүүдийг танилцуулав. 2019 оны ажилтнуудын бүтэц зохион байгуулалтыг шинээр батлав,
		1 өдөр, Улаанбаатар хот	20 хүн (55% эм)	Дундын хоршооны гүйцэтгэх захирал томилов. Бизнес төлөвлөгөөгөөний төсөлтэй танилцав.
		2 өдөр Сэлэнгэ аймаг, Мандал сум	24 хүн (55% эм)	Хоршооны засаглал, менежментийн чиглэлээр зөвлөхүүд танилцуулга хийв. Хоршооны санхүүгийн тайланг гишүүдэд танилцуулав. Бизнес төлөвлөгөөний төсөлтэй танилцав.
		1 өдөр, Сэлэнгэ аймаг, Мандал сум	24 (60% эм)	Хоршооны сайн засаглал сэдэвт сургалт зохион байгуулагдав. Сургалтыг хоршооны зөвлөх багш Г.Мөнх-Эрдэнэ болон Г.Галаарийдий нар зохион байгуулав.

		1 өдөр, Дархан-Уул аймаг, Дархан сум	22 (45% эм)	Дундын хоршооны бүх гишүүдийн хоршооны засаглал, менежментийн талаарх чадавх бэхийжсэн. Бүх гишүүдийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу дараагийн шатны ажлууд төлөвлөгдсөн.
		1 өдөр, Дундын хоршооны Бизнес төслийн анхан шатны хэлэлцүүлэг	38 (50% эм)	2020 оны бизнес төслийн баримт бичигтэй танилцаж, санал өгсөн, бусад асуудлын талаарх тайлан сонсов.
2	Хүнсний ногоо дахин боловсруулах цехийн сургалт	2 өдөр	19 (95% эм)	Цехийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, бүтээгдэхүүнийн өртөг тооцох аргачлал
		2 өдөр	16 (100% эм)	Үйлдвэрлэлийн байран дээрх практик сургалт, цехийн үйлдвэрлэлийг жигдрүүлэх сургалт. Хүнсний ногоо дахин боловсруулахын зөвлөх багш Ё.Урангэрэл
3	Хүнсний ногооны хэрэглээ нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, семинар	15 өдөр, Улаанбаатар хот	231 (95% эм)	Сургалтыг Монгол ногоо зөвлөх багш Н.Оюундарь зохион байгуулав. Сургууль цэцэрлэгийн хүнсний ногоогоор хийх хоолны талаарх тогоочдын мэдэлэг 30% нэмэгдсэн.
		15 өдөр, Сэлэнгэ, Ховд, Завхан, Увс аймаг	265 (90% эм)	Сургалтыг Монгол ногоо зөвлөх багш Н.Оюундарь зохион байгуулав. Сургууль цэцэрлэгийн хүнсний ногоогоор хийх хоолны талаарх тогоочдын мэдэлэг 20% нэмэгдсэн.
4	Хүнсний ногооны маркетинг ба зах зээлийн форум	1 өдөр, Улаанбаатар хот	110 (77% эм)	Зах зээлийн мэдээлэл солилцоо, хамтын ажилагаа, сургалт хэлэлцүүлэг. Маркетингийн ажилтан Ц.Насанжаргал форумыг зохион байгуулав.
	НИЙТ	48 өдөр	789 (83% эм)	

Бүрэлдэхүүн хэсэг 3: Гэр хороолол

Сургалтын нэр	Хугацаа, байршил	Оролцогсод (% эмэгтэй)	Сургалтын үр дүн
Үрслэг ургуулах сургалт	2 сарын 15 Хан-Уул, Налайх, СХД	50 (96% эм)	Үр шим хүртэгчдэд үрслэг бэлтгэх үер газар дээр очиж хийсэн.
Хүлэмжинд хүнсний ногоо тарих ач холбогдол, хүлэмжийн хөрс боловсруулалт	3 сарын 19-нөөс 11 сарын 17 УБ хотын 9 дүүргийн хүлэмж тариалан эрхлэгчид	301 (85% эм)	Сургалтын үр дүнд Хүлэмжийн аж ахуй эрхлэх, хүлэмжийн аж ахуйн давуу тал, ургамал ургуулах таатай нөхцөлийг бүрдүүлж өгөх, хүлэмж барих, үрслэг бэлтгэх, бойжуулах, хүлэмжинд шилжүүлж ургамлаа тарих, танаж арчлах сойх, усалгаа хийх шланк байрлуулах, усалгааны горим, нийлэг хальсыг салхинаас хэрхэн хамгаалж ашиглалтыг сайжруулах, “Атрын шим” ХХК-ны хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцах, өвлийн хүлэмжинд ургасан өргөмт хэмх, улаан лооль, гүзээлзгэний арчилгаа, таналт тайралтыг биечлэн хийж үзүүлсэн. Зорилготой байж зорилгоо бүрэн дүүрэн биелүүлсэн ногоочид маань мэдэх, чадах гэсэн эрмэлзлэлтэй, өөрсдийн туршлага мэдлэгээ хуваалцсан сайхан сургалт болсон. Сургалтанд оролцсон хүмүүсээр дамжуулан бусад өрх иргэд мэдлэг, мэдээлэлтэй болно.
“Хүнсний ногооны үр ашиг, үр үрсэлгээ, хүлэмж, хөрс боловсруулалт” сургалт	5 сарын 08-09 Хөвсгөл, Орхон, Дархан-Уул аймгийн ногоочид	270 (68,8% эм)	Сургалтанд хамрагдсан иргэд хашаандаа ногоо тарих талбай, гарах зардал, олох орлогоо зөв тооцож, үр үрсэлгээг технологийн дагуу ургуулж, ногоо тарих хөрсийг агротехникийн дагуу боловсруулж сурсанаар хүнсний ногоо тарих мэдлэг сайжирч ногоо тарих талбай, ургацын хэмжээ нэмэгдлээ.
“Хүнсний ногооны үр үрсэлгээ, сургалт	3 сарын 04-08 Хөвсгөл, Орхон, Дархан-Уул аймгийн зорилгод бүлгийн үр шим хүртэгчид	86 (65,1% эм)	Сургалтанд оролцсон хүмүүсээр дамжуулан бусад өрх иргэд мэдлэг, мэдээлэлтэй болно.

Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн сургалт	4 сарын 17-ноос 11 сарын 28 Нийслэл, хөдөө орон нутаг	356 (88,2% эм)	Сургалтыг онол, дадлага хосолсон хэлбэрээр явуулсан бөгөөд цэцэрлэгийн тогооч нарт бага насны хүүхдийг шим тэжээл, зохистой хооллолт, хүнсний ногооны ач тус, хүүхдийг хоолыг хүнсний ногоогоор баяжуулах арга зам, хүнсний ногоог хоолонд зөв боловсруулж хэрэглэх талаар онолын мэдлэг олгож, ногоогоор баяжуулсан хоол хийх чадвар эзэмшүүлэв.
Бүлэг бэхжүүлэх, чадваржуулах сургалт	5 сарын 06-наас 7 сарын 19 Хан-Уул, Сонгинохайрхан, Налайх дүүргийн үр шим хүртэгчид 8 сарын 02-03 Эрдэнэт	205 (79,5% эм)	Зохион байгуулагдсан бүлгүүдийн үйл ажиллагааны судалгааг хийж, гишүүдийн хэрэгцээ, шаардлага тодорхой болж цаашид хамтын ажиллагаа сайжирлаа.
Харилцан туршлага судлах аялал	7 сарын 4-нөөс 8 сарын 2	21 (85% эм)	УБ хотын үр шим хүртэгчдээс 9 хүнийг хөдөө орон нутагт ногооны арчилгааны үер явуулж газар дээр нь очиж заавар зөвлөгөө өгөх ажлыг хийлгэж, хөдөө орон нутгийн хүмүүсийг УБ хотод төсөл хэрэгжиж буй газруудын үйл ажиллагаатай танилцуулсан. Энэ нь хоорондоо танилцаж, бие биенээсээ суралцах, туршлагаа хуваалцах боломжуудыг гаргаж өгсөн.
Даршилгааны сургалт	8 сарын 9-нөөс 10 сарын 7 Орон нутагт	93 (81,7% эм)	Сургалтанд хамрагдсан үр шим хүртэгчид ургуулсан ногоо болон жимс жимсгэнийг даршилж, нөөшлөн өрхийн хэрэгцээ хангаж, илүүг нь зах зээлд нийлүүлнэ.
Жишиг гудамж танилцуулах өдөрлөг	9 сарын 6,8 СХД	69 (57,9% эм)	Гудамжаар нь хамт олон, бүлэг болгон ногоо тариулж, услах усны асуудлыг шийдвэрлэн өгч ажиллуулсан “Жишиг гудамж” төслийн загвар нь үр дүнтэй болж байгаа учраас цаашид бусад аймаг, дүүргүүдэд түгээн дэлгэрүүлэх зорилготой энэ үйл ажиллагааг зохион байгуулсан.
Үр дүнгийн семинар /Жишиг гудамж, Загвар өрх/	12 сарын 20	43 (74,4% эм)	Энэ жил үр дүнгийн семинарыг “Жишиг гудамж”, “Загвар өрх”-ийн үр шим хүртэгчдийн дунд зохион байгуулсан. Төслийн ажилтанууд, болон үр шим хүртэгчдийн төлөөлүүдээс төслийн хэрэгжилт, гарсан үр дүн, цаашид хийх ажлын төлөвлөгөөг танилцуулсан.
НИЙТ	62 өдөр	1,494 (68% эм)	

Бүрэлдэхүүн хэсэг 4: Хууль эрх зүй

№	Сургалтын нэр	Хугацаа, байршил	Оролцогсод (% эмэгтэй)	Сургалтын үр дүн
1	“ХААЗД, Органик үйлдвэрлэл, УХЦА болон гарал үүслийн гэрчилгээ” сургалт	1-р сарын 23-25 Төв аймаг – Борнуур сум, Сэлэнгэ аймаг – Мандал сум, Дархан-Уул аймаг – Орхон, Орхон аймаг – Жаргалант	588 (63% эм)	Ургамал хамгааллын арга хэмжээ, УХЦА ХААЗД, органик үйлдвэрлэлийн асуудлыг хамарсан холбогдох хууль тогтоомж, журам, заавар, бодлого, талбайн түүхийн дэвтэр хөтлөх, ул мөрийг мөшгих бүртгэл хөтлөх. Сумдын агроном-төрийн албан хаагчид болон ногоочид оролцсон.
2	“Органик үйлдвэрлэл болон Оролцооны баталгаажуулалт (PGS)” сургалт	4-р сарын 02 Амар зочид буудлын хурлын танхимд	18 (50% эм)	Органик үйлдвэрлэлийн эрх зүйн орчин, техникийн шаардлага, органик хүнсний ногооны ургамал хамгаалах цогц технологи, баталгаажуулалт, оролцооны баталгаажуулалт, хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулах тухай мэдлэг олгоход чиглэгдсэн. Органик үйлдвэрлэлрүү шилжих тангараг өргөсөн сумдын агроном-төрийн албан хаагчид болон ногоочид оролцсон.
3	“Ургамал хамгаалал, хөрсний үржил шимийн менежмент” Төвийн бүсийн сургалт	05-р сарын 03 Дархан-Уул аймаг, Комфорт цогцолборт	58 (55% эм)	Хүнсний ногооны ургамал хамгаалал, голлох хөнөөлт организмыг таних, тодорхойлох, тэмцэх арга, ургамал хамгааллын цогц арга, ургамлын амьдрах орчин болох хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг сайжруулах, хөрсний эдийн засгийн үнэлгээ, органик болон компост бордоо бэлтгэх, тун норм тодорхойлох, хэрэглэх. Сумдын агроном-төрийн албан хаагчид болон ногоочид оролцсон.

4	“Ургамал хамгаалал, хөрсний үржил шимийн менежмент” Төвийн бүсийн сургалт	06-р сарын 03 Хэнтий аймаг, Чингис хаан хот, Эзэнт Гүрэн зочид буудлын хурлын танхим	49 (63% эм)	Хүнсний ногооны ургамал хамгаалал, голлох хөнөөлт организмыг таних, тодорхойлох, тэмцэх арга, ургамал хамгааллын цогц арга, ургамлын амьдрах орчин болох хөрсийг хамгаалах, түүний үржил шимийг сайжруулах, хөрсний эдийн засгийн үнэлгээ, органик болон компост бордоо бэлтгэх, тун норм тодорхойлох, хэрэглэх. Сумдын агроном-төрийн албан хаагчид болон ногоочид оролцсон.
5	Хүнсний сүлжээний туршид аюулгүй байдал, чанарыг тогтвортой хангах нь” сэдэвт чадавхийг бэхжүүлэх Үндэсний семинар (Монголын Бүтээмжийн Төв, Глобал Комюнитис-тэй хамтарсан	5-р сарын 16-17 ХХААХҮЯ-ны хурлын зааланд	34 (65 % эм)	Хүнсний сүлжээний туршид аюулгүй байдал, чанарыг тогтвортой хангах тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн олон улсын туршлага, загвар, хүнсний бүтээгдэхүүний ул мөрийг мөшгин тогтоох бүртгэлийн тогтолцоо, үндсэн загварууд, хүнсний сүлжээний туршид аюулгүй байдал, чанарыг тогтвортой хангах тогтолцоог бүрдүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулах, хүнсний сүлжээний анхан шатны үйлдвэрлэлд ХААЗД-ыг үр дүнтэй нэвтрүүлэх, баталгаажуулах тогтолцоо бүрдүүлэх. Салбарын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, судлаачид, хүлэмжийн аж ахуй эрхлэгчид оролцов.
6	Хамтын баталгаажуулалтын байгууллагын чиглүүлэх сургалт	5-р сарын 27-28 SFCS ХХК-ийн сургалтын байранд	24 (65% эм)	Сургалтаар ХББ-г байгуулах, бүртгүүлэх, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн орчин, баталгаажуулалт хийх зарчим, техникийн арга зүйг танхимын хичээлээр зааж сургасан. Сургалтын 2 дахь өдөр эхний өдөр олж авсан мэдлэг, мэдээллэлдээ тулгуурлан органик хүнсний оролцооны аргаар баталгаажуулах схемийг боловсруулан, Гэр Гарден ХХК-ийн хүлэмжийн аж ахуй дээр очиж баталгаажуулалтын хяналт шалгалтыг гүйцэтгэсэн. Органик Хөгжил ХББ болон Борнуур Органик Хүнс ХХБ-ын гишүүд болон бусад сонирхогч гишүүд оролцов.
7	ХААЗД-ын дотоод аудитуудын сургалт	8-р сарын 29 SFCS ХХК-ийн сургалтын байранд	25 (52% эм)	ХААЗД-ын баримтжуулалт, дотоод аудит хийх техникийн аргачлалын тухай. МХГ-ын 11 аймгийн байцаагч нар болон ногоочид, үйлдвэрлэгчдийн төлөөлөл оролцов.
8	Органик үйлдвэрлэгчдийн IY чуулган	10 сарын17 Чингис зочид буудал	160 (73% эм)	Уг форумаар органик хөдөө аж ахуйг хамтын зарчмаар баталгаажуулахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг хэлэлцэж, цаашид энэ чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг ярилцлаа.
9	ХААЗД-ыг нэвтрүүлэх нь үндэсний сургалт	12 сарын 07 Блү Скай зочид буудлын 2 давхарт	113 (61% эм)	“Жимс жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” батлагдсаны дараагаар уг зааврыг ногоочдод таниулах, зааврыг хэрэгжүүлэх технологийн зүгээс чиглүүлэх. ХХААХҮЯ-ны төлөөлөл, МХЕГ-ын УБ хот болон аймгуудын байцаагч нар, мэргэжлийн холбоод, судлаач шинжээчид, ногоочид, үйлдвэрлэгчид
10	“Ургамал Хамгааллын Цогц Арга” сургагч багшийн сургалт	12 сарын 16, 17 Чингис зочид буудал	50 (70% эм)	Уг сургалтанд судлаач, шинжээчид түлхүү оролцсон бөгөөд гол хөнөөлт хортон, шавьж, тэдгээрийн харилцан хамаарал зэрэг мэргэжлийн сэдвээс гадна УХЦА-ыг Азийн бусад орнуудад хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар сайн туршлагаас хуваалцлаа.
	НИЙТ	20 өдөр	955 (60% эм)	

Стратеги		Үндсэн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Оноор					Мэдээллийн эх сурвалж
			2015	2016	2017	2018	2019	Нийт дүн	
Төслийн үндсэн зорилго нь хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулах юм.	1	Эдийн засаг (орлого нь нэмэгдсэн Суурь: 1,415,159 (2016) Зорилт: >20% (2019) төгрөгөөр		1,415,159	1,637,069 16%	3,325,299 135%	-		Төсөл хэрэгжих хот, сум, дүүргүүдэд ядуурлын судалгааг хийх. 2016 оны 1 дүгээр сард эхлэн, явцын судалгааг 2017, 2019 онд хийнэ.
	2	Улс төр (хоршоололуудын хийсэн гэрээний тоо Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019)		-	2	3	4	9	
	3	Нийгэм (хамтарсан үйл ажиллагаануудын тоо)		14	14	23	8	51	
	4	Хүн (усны олоц) <i>өрхөөр</i>		61	91	60	118	330	
	5	Аюулгүй байдал (зоорины хангамж) <i>тонноор</i>		3,648	3,836	3,881	-		
	6	Амьжиргаа дээшилсэн байдал (чанарын)							
	7	Нэг хүнд оногдох хүнсний ногооны жилийн хэрэглээ (кг) Суурь: 39 кг (2015), Зорилт: 60 кг (2019)	39	54	48	57	51		Үндэсний статистикийн хороо (ҮСХ) болон ХХААХҮЯ
	8	Улсын хэмжээнд тариалсан хүнсний ногооны талбайн хэмжээ (га) Суурь: 6,800 га (2015) Зорилт: 9,000 га (2019)	6,800	9,052	8,357	8,866	8,290		
	9	Хүнсний ногооны дундаж ургац (кг/га) Суурь: 11 т/га (2015); Зорилт: 15.0 т/га (2019)	10	11	10	12	12		
Зорилтууд		Шалгуур үзүүлэлтүүд							
Зорилт 1: Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	10	Албан ёсоор батлагдсан сортын тоо (байцаа, сонгино, лууван, манжин): Суурь: 5 шинэ сорт (2016); Зорилт: 10 шинэ сорт (2019)		5	5	2	2	14	ХХААХҮЯ болон ҮСХ-ны албан мэдээ
	11	Зорилтот бүсийн хүнсний ногоо тариалах талбай (га) Суурь: 2,708 (2015) Суурь: >20% (2019)	2,708	3,625 34%	3,064 13%	3,341 23%	3,384 25%		Хүнсний ногооны төслийн ядуурлын судалгаа, төслийн мониторингийн үр дүн
	12	Зорилтот бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэл Суурь: 25,591 тн (2015) Зорилт: >20% (2019)	25,591	35,459 38%	26,489 3%	41,492 62%	41,842 63		
Зорилт 2: Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна.	13	Зорилтот өрх бүрийн хүнсний ногооноос олох жилийн дундаж орлого Суурь: 764,186 ₮ (2016), Зорилт: > 20% (2019)		764,186	871,172 14%	2,840,467 272%			Ядуурлын судалгаа
	14	Хоршооллоор дамжуулж зарсан хүнсний ногооны хувь (%): Суурь: 0 (2016) Зорилт: > 20% (2019)		0%	0%	5%	5%		Хоршоолол болон хувийн хэвшлийн хүнсний ногооны борлуулалтын жил бүрийн үнэлгээ (Хүнсний ногоо төсөл)

		15	Хоршоолол, хувийн хэвшлийн хооронд зурагдсан идэвхтэй гэрээний тоо: Суурь: 0 (2016); Зорилт: 10 (2019)		-	2	3	1	6	
Зорилт 3: Хот болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдсэн байна.		16	Хүнсний ногоо тариалж буй өрхийн тоо: Суурь: 700 (2016); Зорилт: 2400 (2019)	700	2,847	1,931	2,113	2,133		төслийн мониторингийн үр дүн
		17	Хүнсний ногоо тариалж, борлуулж, хэрэглэхэд үүсэх үнэ цэнэ, төгрөгөөр; Суурь: 160,000 ₮ (2016); Зорилт: >30% (2019)		160,000	206,400 29%	209,600 31%	224,000 40%		Ядуурлын судалгаа
Зорилт 4: Хүнсний ногооны салбарын бодлого/хууль эрх зүйн орчин сайжирсан байна.		18	Хүнсний ногооны салбарын ургамал хамгааллын цогц аргын үйл ажиллагааны хөтөлбөр		-	0	0	1	1	Хуулийн бичиг баримт, бусад статистик
		19	Органик хөдөө аж ахуйг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах		-	6	1	1	8	Органик хөдөө аж ахуйд хэрэглэх бодисын жагсаалт
		20	Ургамал хамгааллын бодисын эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох, УХБ-ын үлдэгдэл, хяналт		-	0	1	1	2	
Үр дүнгүүд		Шалгуур үзүүлэлтүүд								
Зорилт 1-г: Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, ноу-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.										
Үр дүн 1.1	Орон нутагт сайн чанарын баталгаатай үрийн олоцтой болсон байна	1	Туршилтанд оруулсан сортын тоо: Суурь: 5 (2016); Зорилт: 40 (2019)	144	71	65	94	20		төслийн мониторингийн үр дүн
		2	Үндсэн хүнсний ногооны төрлийн үрийг дотоодод үйлдвэрлэх, /эрэлтийн Х хувиар/. Суурь: 60% (2015); Зорилт: 80% (2019)	60%	80%	100%	100%	100%		УГТЭШХ-гийн тайлан
		3	Үр дотооддоо үйлдвэрлэж байгаа хүнсний ногооны төрөл: Суурь: 6 (2016); Зорилт: 10 (2019)		7	11	11	12		
Үр дүн 1.2	Хүнсний ногоо үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтэрсэн байна	4	Зорилтот бүсийн хүлэмжийн тариалалт Суурь: 61,889м2 (2016) Зорилт: >10%	61,889	6%	10%	15%	18%	11,168	төслийн мониторингийн үр дүн
		5	Шинэ технологийг туршиж, түгээх Суурь:0 (2016) Зорилт: 5 (2019)	0	4	4	4	12		
		6	Жил бүр сургалтанд хамрагдсан тариаланчид: Суурь: 0 (2015); Зорилт: 2,000 (2019), дор хаяж 50% эмэгтэй	0	357/51% эм	639/56% эм	527/72%эм м	265/58%эм)	1,788	
Үр дүн 1.3	Тариаланчдын мэдлэг дээшилсэн байна	7	Тариаланчдын зөвлөх үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа байдал: Суурь: Тодорхой болгох (2016); Зорилт: 50% (2019)	0	20%	80%	81%	81%		төслийн мониторингийн үр дүн
		8	Сумын түвшинд бий зөвлөх/экстейншин төвийн тоо: Суурь: 0 (2016); Зорилт: 5 (2019)	0	1	3	2	-	6	Тариаланчдын сэтгэл ханамжийн судалгаа

Үр нөлөө 1-д гаргасан үр дүнгийн өртөг: 1) ШХА-ийн оруулах хувь нэмэр: 1,724,000 швейцарь франк 2) МУЗГ-ийн оруулсан хувь нэмэр: 200,000 швейцарь франк 3) Нийт өртөг: 1,924,000 швейцарь франк										
Зорилт 2-т: Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна.										
Үр дүн 2.1	Маркетингийн (тариаланчдын бүлэг/ хоршооны) нэгдмэл үйл ажиллагааны суурь тавигдана	9	Маркетингийн үйл ажиллагаа явуулдаг хоршооны тоо (аймаг, сумаар), Суурь: 0 (2016); Зорилт: 10 (2019)		4	3	1	-	8	Хоршооллын үнэлгээ
		10	Ногоочны хувийн зoorь (Ху3)/хоршооны (Хо3) зoorьны тоо Ху3 – Суурь: 0 (2016) Зорилт: 20; Хо3 – Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019) (аймаг, сумаар)		Ху3 12 Хо3 2	Ху3 13 Хо3 6	Ху3 8 Хо3 4	Хо3 1	Ху3 33 Хо3 13	төслийн мониторингийн үр дүн
		11	Сургалтанд хамрагдсан хоршооны тэргүүний тоо: Суурь: 0 (2016) Зорилт: жил бүр 50, дор хаяж 30 хувь нь эмэгтэй		198	117	75	60		төслийн мониторингийн үр дүн
Үр дүн 2.2	Маркетингийн сувгууд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд орно	12	УБ-ын тариаланчдад нээлттэй бөөний худалдааны төвийн тоо.Суурь: 1 (2016) Зорилт: 3 (2019)		1	1	5	-	7	Маркетингийн судалгаа
		13	Хоршоонд нэгдэж орсон гишүүн тариаланчдын тоо: жилд 50 (дор хаяж 50% нь эмэгтэй)		48/56% эм	54/61% эм	28/64% эм	38/60% эм	168	төслийн мониторингийн үр дүн
		14	Ногоочдын бүлэг болон хоршоодын бөөний худалдаан зах зээлд нийлүүлж буй ногооны үнийг шууд талбайгаас нийлүүлж буй үнээс нэмэгдүүлэх (+>20%) Суурь: Тодорхой болгох (2016) Зорилт: > 20% (2019)		0%	0%	42%	20%		
Үр дүн 2.3	Зах зээлийн оролцогч талууд Зах зээлийн мэдээллийг авах боломжтой болсон байна	15	Худалдааны гэрээ байгуулсан тоо Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019)		-	2	3	1	6	төслийн мониторингийн үр дүн
		16	Сургалтын тоо Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019) нийт тариаланчдад 500, үүний дор хаяж 50% нь эмэгтэй		9	17	11	4	41	төслийн мониторингийн үр дүн Хэвлэлийн мэдээ
		17	Зах зээлийн мэдээллийн эх үүсвэр (цахим хуудас, нийтлэл, гэх мэт.) Суурь: 0 (2016) Зорилт: 5 (2019)		3	2	3	3	11	
		18	Хүнсний ногооны хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх кампант ажлууд Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019)		5	3	4	1	13	
Үр дүн 2.4	Хүнсний ногоо боловсруулах	19	Хүнсний ногоо боловсруулах санаачлагыг дэмжих Суурь: 0 (2016) Зорилт: 10 (2019)		1	5	12	7	25	Маркетингийн судалгаа

	санаачлагуудыг дэмжсэн байна	20	Тухайн орон нутагт боловсруулсан хүнсний ногооны ноогдох хувь Зорилт: 0 (2016) > 10% (2019)		0.8%	1%	1%	0.5%		төслийн мониторингийн үр дүн
Үр нөлөө 2-т гаргасан үр дүнгийн өртөг: 1) ШХА-ийн оруулах хувь нэмэр: 1,194,000 швейцарь франк 2) МУЗГ-ийн хувь нэмэр: 200,000 швейцарь франк 3) Нийт өртөг: 1,394,000 швейцарь франк										
Зорилт 3-т: Хот болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдсэн байна.										
Үр дүн 3.1.	Эмзэг бүлгийн өрхүүд сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээлэлээр хангагдсан байна	21	Хүнсний ногоо үйлдвэрлэгчдийн тоо Суурь: 100, дор хаяж 50% эмэгтэй (2016) Зорилт: 200, дор хаяж 50% эмэгтэй (2019)	0	73	103	74			төслийн мониторингийн үр дүн
		22	Өрх бүрт үйлдвэрлэсэн хүнсний ногооны хэмжээ (кг): Суурь: 0 (2016) Зорилт: 300 (2019)		199	250	244	246		Хөдөө аж ахуйн газрууд (УБ, Дархан, Эрдэнэт)
		23	Төслөөс дэмжсэн хүлэмжийн тоо: Суурь: 0 (2016) Зорилт: 200 (2019)	0	60	37	41	39	177	
Үр дүн 3.2	Хот болон хот орчмын эмзэг, бүлгийн (ялангуяа өрх толгойлсон эмэгтэй) өрхүүдийн хүнсний ногоо тариалалт нэмэгдсэн байна	24	Өрхийн тариалангаар ургуулсан ногооны хувь ба өөрсдийн хэрэгцээнд ашигласан хувь (%): Суурь: 10% (2016) Зорилт: 50% (2019)		74%	58%	58%	70%		төслийн мониторингийн үр дүн
		25								
Үр дүн 3.3	Хот болон хот орчмын бүсэд хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлнэ	26	Үйлдвэрлэл, хүнсний ногооны хэрэглээнд суралцсан өрхийн гишүүдийн тоо (эр/эм): Суурь: 900 эр 400/ эм 500 (2016) Зорилт: 3,000 эр 1,200/ эм 1,800 (2019)		736 эр/1,721 эм	628 эр/1,465 эм	505 эр/1,179 эм	167 эр/1,001 эм		төслийн мониторингийн үр дүн
		27	Зөвлөгөө өгөх цэгийг хороо бүрт байгуулсан байх: Суурь: 0 (2016), Зорилт: 15 (2019)		9	5	8	26	48	Мэдээлэл / сургалтын материал
		28	Хэвлүүлсэн ном товхимолын тоо Суурь:0 (2016) Зорилт: 30 (2019)		4	11	6	8	29	
Үр нөлөө 3-т гаргасан үр дүнгийн өртөг: 1) ШХА-ийн оруулах хувь нэмэр: 1,067,000 швейцарь франк 2) МУЗГ-ийн оруулсан хувь нэмэр: 100,000 швейцарь франк 3) Нийт өртөг: 1,167,000 швейцарь франк										
Зорилт 4-т: Хүнсний ногооны салбарын бодлого/хууль эрх зүйн орчин сайжирсан байна.										
Үр дүн 4.1	Ургамал хамгааллын цогц менежмент, пестицид, органик газар тариалангийн хуулийн бодлогыг боловсруулна	50	Одоогийн бодлогыг судлан шинжилсэн байх			1	1	-	2	ХХААХҮЯ/ХХААБ
		51	Ургамал хамгаалалын цогц менежмент, пестицид, органик тариалангийн эрх зүйн зохицуулалт (тус бүрт 1)		0	5	1	1	7	
Үр дүн 4.2	Төрийн холбогдох мэргэжилтэнүүд ургамал хамгаалалын цогц	52	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо		0	175	220	382	1,377	ХХААХҮЯ/ХХААБ
		53	Боловсруулсан Ажлын даалгаврын тоо Суурь: 0 (2016) Зорилт: 5 (2018)		1	4	4	2	11	

	менежмент болон органик газар тариалангийн талаарх мэдлэг чадвартай болсон байна									
Үр дүн 4.3	Ургамал хамгааллын цогц менежмент, пестицид, органик газар тариалангийн зохицуулалтыг туршин, хэрэгжүүлж, баримтжуулсан байна	54	Ургамал хамгаалалын цогц нэгдсэн менежментийн хөтөлбөрийг туршин явуулах		0	1	8	3	11	ХХААХҮЯ/ХХААБ
		55	Органик хөдөө аж ахуйн гарал үүслийн системийг туршин явуулах		0	0	8	2	10	
		56	Зарим тариаланд биологийн ургамал хамгаалалын цогц менежментийн аргыг туршин явуулах			3	0	2	5	
Үр нөлөө 4-т гаргасан үр дүнгийн өртөг: ШХА-ийн оруулах хувь нэмэр: 400,000 швейцарь франк										